



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТӨД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗОРИЛГЫГ ТУСГАХАД АШИГЛАХ АРГА ХЭРЭГСЭЛ

Тайлан II

УЛААНБААТАР ХОТ
2020 он



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР

**ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТӨД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ЗОРИЛГЫГ ТУСГАХАД АШИГЛАХ
АРГА ХЭРЭГСЭЛ**

ТАЙЛАН **2**

УЛААНБААТАР ХОТ
2020 он

Энэхүү тайланг Азийн хөгжлийн банк (АХБ)-ны "Тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилгыг Ази-Номхон далайн бүс нутгийн улс орнуудад хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл (ТА-9245)"-ийн хүрээнд Монгол Улсын Үндэсний хөгжлийн газраас эрхлэн боловсруулав.

Уг тайланг мэдлэг олгох болон ашгийн бус зорилгоор бүтэн эсхүл хэсэгчилсэн байдлаар ашиглаж болно. Чингэхдээ зохиогчдоос тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй боловч эх сурвалжийг зайлшгүй дурдах шаардлагатай.

Тайлангийн агуулга, мэдээлэл нь Монгол Улсын Засгийн газрын албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

Удирдан чиглүүлж, хянан тохиолдуулсан:

Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ж.Должинсүрэн
Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн С.Сюзанна

Зөвлөхүүд:

Шинжлэх ухааны академийн Газарзүй-геоэкологийн хүрээлэнгийн салбарын дарга,
доктор М.Алтанбагана
Шведийн Вант Улс дахь "Outcome Consulting" ХХК-ийн захирал, доктор Горан Нилсон Ахберг
(Goran Nilsson Axberg)
Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн ахлах эдийн засагч,
магистр Д.Цэнддорж

Хэвлэлд бэлтгэсэн:

Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Р.Сийлэн

Энэхүү тайланг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн Эмма Марсден (АХБ), Тая Концепцион (АХБ), Р.Болор (төслийн үндэсний зохицуулагч) нарт гүн талархал илэрхийлье.

Холбоо барих:

Үндэсний хөгжлийн газар
Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн Үндэстний Гудамж 5/1
Цахим хуудас: www.nda.gov.mn
Утас: 976-51-263333

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГ

АШИГЛАСАН НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНТОЙ ХОЛБООТОЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУДЫГ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТӨД ТУСГАХАД АШИГЛАХ АРГА ХЭРЭГСЭЛ (TOOL)

2. АРГА ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХ АРГАЧЛАЛ

2.1. Зорилго.....	10
2.2. Хамрах хүрээ	10
2.3. Зарчим.....	10
2.4. Арга хэрэгсэл (tool)-ийг ашиглах заавар	11
2.5. Чанарын оноо өгөх заавар.....	12
2.6. Чанарын шинжилгээний үр дүнгийн тайлал, дүгнэлт өгөх заавар.....	13
2.7. Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогод хийсэн туршилтын шинжилгээ.....	16

ХАВСРАЛТ. АРГА ХЭРЭГСЭЛД ТУСГАГДСАН 48 АСУУЛТ ДАХЬ ТҮЛХҮҮР ҮГ, ОЙЛГОЛТЫН ТАЙЛБАР

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ТОВЧИЛСОН ҮГ

АХБ	Азийн хөгжлийн банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
МУТХҮБ-2030	Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
СЭХ	Сэргээгдэх эрчим хүч
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
УИХ	Улсын Их Хурал
УННМ	Усны нөөцийн нэгдсэн менежмент
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Энэ хэсэгт арга хэрэгсэл болон гарын авлагад тусгасан гол нэр томьёоны тайлбарыг харуулав.

АРГА ХЭРЭГСЭЛ (tool) гэдэгт эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхээр аливаа салбараас санаачлан боловсруулж буй хөгжлийн бодлогын баримт бичиг тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтуудыг уялдуулан тусгахад ашиглах арга хэрэгсэл бүхий аргачилсан зааврыг ойлгоно.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО гэдэгт дэлхий нийтээр хэрэгжүүлж буй Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг ойлгоно. Тухайлбал, Тогтвортой хөгжлийн зорилго 6-д “Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах” зорилгыг дэвшүүлсэн.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ гэдэгт Тогтвортой хөгжлийн 17 зорилгын хүрээнд дэвшүүлсэн 169 зорилтыг ойлгоно. Тухайлбал, Тогтвортой хөгжлийн зорилт 6.1-д “2030 он гэхэд хүн бүрийг ундны аюулгүй, боломжийн үнэтэй усаар хангах” гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ гэдэгт Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 4.1.1 - 4.1.11-д заасан, үндэсний, салбарын, салбар хоорондын богино, дунд болон урт хугацааны хөгжлийн зорилго, зорилтууд, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгууруудыг тодорхойлсон баримт бичгийг ойлгоно.

БОДЛОГЫН ЗОРИЛТ гэдэгт Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 9.4-д заасны дагуу “асуудлыг хэсэгчлэн болон бүрэн шийдвэрлэхэд чиглэсэн Засгийн газраас аливаа бодлогын хүрээнд дэвшүүлсэн оновчтой, хэмжиж болохуйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц эерэг өөрчлөлт” гэж ойлгоно.

АСУУЛГА гэдэгт Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой сонгон авсан зорилго, зорилт болон тэдгээрийн үндэсний түвшинд тодорхойлсон шалгуур үзүүлэлтэд тулгуурлан боловсруулсан ШАЛГУУР АСУУЛТЫГ ойлгоно. Эдгээр асуултууд нь аливаа салбараас дэвшүүлж буй хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах үйл явцад чанарын шинжилгээ хийхэд ашиглагдах арга хэрэгсэл (tool)-ийн үндсэн бүрэлдэхүүн юм.

ЧАНАРЫН ОНОО гэдэгт Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилго, үндэсний түвшинд тодорхойлсон шалгуур үзүүлэлтэд тулгуурлан боловсруулсан асуулт бүрээр эдийн засаг, нийгмийн аль нэг салбарын хүрээнд шинээр боловсруулж буй бодлого, хөтөлбөрийн төслийн зорилго, зорилтод тогтвортой хөгжлийн байгаль орчны асуудал тусгалаа олсон эсэх, дэвшүүлсэн бодлогын зорилго, зорилтын улмаас байгаль орчинд бий болох эерэг, сөрөг нөлөөг чанарын оноогоор үнэлсэн дүнг ойлгоно.

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

НҮБ-ын бүх гишүүн орнуудын 2015 онд хамтран «Даян дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр - 2030»-ийг батламжилсан бөгөөд энэ нь хүн төрөлхтний өнөөгийн болон болон ирээдүй хойч үеийн энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх эв санааны нэгдлийн илрэл юм. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2030 он гэхэд дэлхий нийтээр ядуурлыг эцэс болгох, өлсгөлөнг үгүй хийх, эх дэлхийгээ хамгаалах, шударга ёсыг түгээн дэлгэрүүлэх, тэгш бус байдлыг арилгах, хөгжил цэцэглэлтэд хүрэх 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлт бүхий тогтвортой хөгжлийн төлөөх 17 зорилгыг дэвшүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурал 2016 онд «Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030» (МУТХҮБ-2030)-ыг дээрх 17 зорилготой уялдуулан баталснаар үндэснийхээ урт хугацааны бодлогод Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын үзэл санааг тусгасан анхдагч улс орны нэг болсон төдийгүй ТХЗ-ыг нутагшуулах ажлын эхлэлийг тавьсан юм. Үүний сацуу «Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль» 2016 онд хүчин төгөлдөр болсон нь бодлого төлөвлөлтийн болон институцийн цогц механизмыг хэрэгжүүлэх эрх зүйн орчны үндэс суурийг бүрдүүлсэн түүхэн ач холбогдол бүхий үйл явдал байв.

Үндэсний хөгжлийн газар (ҮХГ) нь ТХЗ-ыг хөгжлийн бодлогод тусган нутагшуулах ажлыг чиглүүлэх үүрэгтэй Засгийн газрын тохируулагч байгууллага юм. Чингэхдээ ТХЗ хоорондын уялдаа хамаарлыг алдагдуулалгүй, нэгдмэл байдлыг нь хадгалан, хөгжлийн бодлого төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан аливаа бодлогод тусгахыг эрмэлздэг. Үүнийг эш болгон ҮХГ-аас бодлогын уялдаа холбоог үнэлэх матрицад суурилсан арга хэрэгслийг боловсруулж Засгийн газраар батлуулах зэргээр бодлого төлөвлөгчдөд нэн шаардлагатай арга зүй, аргачлалыг боловсруулж, түгээн дэлгэрүүлэхээр ажиллаж байна. Тухайлбал «ТХЗ-ын хэрэгжилтийн Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2019»-д систем шинжилгээний аргыг ашиглан хөгжлийн тулгамдсан асуудлын нэг болох агаарын бохирдолд шинжилгээ хийсэн нь салбар дамнасан бусад асуудлыг шийдвэрлэхэд ашиглаж болохуйц жишиг загвар болсон юм.

Ийнхүү тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа ч салбарын яам, агентлагууд нь байгаль орчин, эдийн засаг, нийгэм гэсэн хөгжлийн гурван тулгуурыг салангид авч үзэх, уялдаа холбоонд нь бус өөрсдийн хариуцсан асуудал чиг үүргийн хүрээнд салгах нь түгээмэл байна. Үүний нэг илрэл нь байгаль орчны салбарын бодлогын зорилтуудтай уялдаа холбоо сул эдийн засаг, нийгмийн салбарын өнөөгийн бодлогын нөхцөл байдал юм. Тиймээс бодлого боловсруулагчдад зориулан эдийн засаг, нийгмийн салбарын бодлогод байгаль орчинтой холбоотой тогтвортой хөгжлийн зорилгыг уялдуулан тусгах боломжийг бүрдүүлсэн арга хэрэгсэл болон аргачилсан зааврыг боловсруулан хүртээл болгох нь чухал юм.

ҮХГ-аас АХБ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй «Тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилгыг Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудад хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх» төслийн хүрээнд байгаль орчинтой холбоотой ТХЗ-ыг нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогыг боловсруулах шатанд нь уялдуулахад ашиглах бодлого, төлөвлөлтийн чанарын шинжилгээний хялбар арга хэрэгслийг боловсруулахыг зорьсон. Энэ ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж, үр дүнг нь дараах гурван тайланд нийтэллээ.

Тайлан 1. Эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжлийг хангахтай холбоотой арга хэрэгслийн судалгааны тайлан

Тайлан 2. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд Тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилгыг тусгахад ашиглах арга хэрэгсэл

Тайлан 3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтыг тусгах арга хэрэгслийг ашиглан эрчим хүч болон эрүүл мэндийн салбарын бодлогод хийсэн туршилтын шинжилгээний үр дүн.

Төслийн хүрээнд боловсруулагдах энэхүү тайлангийн зорилго нь шинээр боловсруулж буй нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогын зорилтуудыг байгаль орчны тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах нөхцөлийг бүрдүүлэх явдал юм. Үүний зэрэгцээ, арга хэрэгслийн тусламжтайгаар талуудын дунд зөвшилцөл, нэгдсэн ойлголт бий болгох явдал юм.

1. Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтуудыг эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд уялдуулан тусгахад ашиглах арга хэрэгсэл (tool)

№	ТХЗ-ын зорилт	АСУУЛГ	Бодлогын баримт бичгийн төсөл дэх бодлогын зорилт							Нийлбэр оноо
			1	2	3	4	5	...	N	
1	2.4	Бүтээмжтэй, тогтвортой хөдөө аж ахуйн газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
2	2.5	Устах эрсдэлтэй нутгийн үүлдрийн цөм сүргийг өсгөж, үржлийн чанарыг сайжруулахад ямар нөлөө үзүүлэх вэ?								
3	3.9	Аюултай химийн бодис, агаар, ус, хөрсний бохирдол, халдвараас шалтгаалсан өвчлөлт, нас баралтыг бууруулахад ямар нөлөө үзүүлэх вэ?								
4	4.7	Бүх шатны боловсролын тогтолцоонд тогтвортой хөгжлийн боловсролыг тусгахад ямар нөлөө үзүүлэх вэ?								
5	6.1	Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
6	6.2	Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
7	6.3	Хаягдал усыг цэвэрлэж, дахин болон эргүүлэн ашиглах усны хэмжээг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
8	6.4	Усны хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
9	6.5	Усны нөөцийн нэгдсэн менежмент (УННМ)-ийн төлөвлөгөөний зорилтуудад ямар нөлөө үзүүлэх вэ?								
10	6.6	Усны эх, ой, голын татам, намагшсан газар, нуур, гол мөрөн, уст давхаргыг хамгаалах, сэргээхэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
11	6.A	Ус хангамж, ариун цэврийн байгууламж, ус хураах, цэвэршүүлэх, бохир усыг цэвэрлэх, усны үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой хөгжлийн тусламжийг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
12	6.B	Ус хангамж болон ариун цэврийн байгууламжийн менежментийг боловсронгуй болгох чиглэлээр орон нутаг, талуудын оролцоог дэмжих, бэхжүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
13	7.1	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
14	7.2	Эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
15	7.3	Эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
16	8.9	Аялал жуулчлалын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
17	9.4	ДНБ-нд ногдох нүүрстөрөгчийн ялгарлын хэмжээг бууруулахад ямар нөлөө үзүүлэх вэ?								
18	11.3	Ногоон хот, суурин газрыг хөгжүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
19	11.4	Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалахад ямар нөлөө үзүүлэх вэ?								
20	11.6	Хот, суурин газрын орчны бохирдол (агаар, ус, хөрс)-ыг бууруулахад ямар нөлөө үзүүлэх бэ?								
21	11.7	Нийтийн хэрэгцээний, тусгай зориулалтын ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
22	11.A	Тогтвортой, ногоон хот, суурин газар амьдарч байгаа хүн амын тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх бэ?								
23	11.B	Хот, суурины гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зорилтуудыг хэрэгжүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
24	12.1	Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжихэд ямар нөлөө үзүүлэх вэ?								
25	12.2	Байгалийн нөөц, баялгийг үр ашигтай ашиглахад ямар нөлөө үзүүлэх вэ?								

26	12.3	Үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээний түвшинд хүнсний хаягдлыг бууруулахад ямар нөлөө үзүүлэх вэ?																		
27	12.4	Нэг хүнд ногдох аюултай хог хаягдлыг бууруулах болон устгасан хог хаягдлын эзлэх хувийн нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?																		
28	12.5	Дахин боловсруулсан, ашигласан хог хаягдлын эзлэх хувийг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?																		
29	12.6	Тогтвортой байдлын тайлан гаргадаг компаниудын тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?																		
30	12.7	Тогтвортой байдалд чиглэсэн төрийн худалдан авах ажиллагааг дэмжихэд ямар нөлөө үзүүлэх вэ?																		
31	12.8	Тогтвортой хөгжил, байгаль дэлхийтэйгээ зохицон амьдрах талаар мэдлэг, мэдээлэлтэй хүн амын тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?																		
32	12.A	Байгаль орчинд ээлтэй технологи, үйлдвэрлэл, тогтвортой хэрэглээнд зориулсан судалгаа, хөгжлийн тусламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?																		
33	12.C	Хатуу түлш (нүүрс, мод)-ний хэрэглээ, үйлдвэрлэлд төрөөс үзүүлэх татаас/дэмжлэгийг зохистой түвшинд хүргэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?																		
34	13.1	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой аюул, байгалийн гамшгийг даван туулах, тэдгээрт дасан зохицох чадавхыг бэхжүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?																		
35	13.3	Бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөрт уур амьсгалын өөрчлөлт, гамшгийг бууруулах, дасан зохицох, урьдчилан сэргийлэх талаарх агуулга тусгасан хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?																		
36	14.4	Загасны нөөцийг тогтвортой түвшинд хадгалахад ямар нөлөө үзүүлэх вэ?																		
37	15.1	Ойгоор бүрхэгдсэн, тусгай хамгаалалтад авсан газрын хэмжээг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?																		
38	15.2	Ойг нөхөн сэргээх, зохистой ашиглах, хамгаалахад ямар нөлөө үзүүлэх вэ?																		
39	15.3	Цөлжилт, газрын доройтлыг бууруулахад ямар нөлөө үзүүлэх вэ?																		
40	15.4	Өндөр уулын бүсийн экосистем (биологийн олон янз байдал хамаарна)-ыг хамгаалахад ямар нөлөө үзүүлэх вэ?																		
41	15.5	Биологийн олон янз байдлын хомсдол, амьдрах орчны доройтлыг зогсооход ямар нөлөө үзүүлэх вэ?																		
42	15.6	Генетик нөөцийн ашгийг шударга, эрх тэгш хуваарилах, зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?																		
43	15.7	Ургамлын болон амьтны аймгийн хамгаалагдсан төрөл зүйлийг хууль бусаар агнах, зэрлэг ан амьтдын худалдааг багасгахад ямар нөлөө үзүүлэх вэ?																		
44	15.8	Хуурай газар, усны экосистемд харь зүйл нэвтрэх боломж, сөрөг үр дагаврыг бууруулах, сэргийлэх арга хэмжээ авахад ямар нөлөө үзүүлэх вэ?																		
45	15.9	Экосистем, биологийн олон янз байдлын үнэ цэнийг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тооцоонд тусгахад ямар нөлөө үзүүлэх вэ?																		
46	15.A	Биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах, тогтвортой ашиглахад зориулсан санхүүгийн эх үүсвэр, хөрөнгө бүрдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?																		
47	15.B	Ойн нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалахад чиглэсэн хөгжлийн тусламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?																		
48	15.C	Ургамал, амьтны хууль бус бэлтгэл, ашиглалт, тээвэрлэлтийг бууруулахад ямар нөлөө үзүүлэх вэ?																		
Нийлбэр оноо																				Бүгд оноо

1 Жич: Арга хэрэгсэлд тусгагдсан 48 асуултыг тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилт, тэдгээрийн үндэсний түвшинд тодорхойлсон шалгуур үзүүлэлтэд тулгуулан тодорхойлсон бөгөөд асуултын зарим түлхүүр үг, ойлголтын тайлбарыг хавсралтаас үзнэ үү.

2. АРГА ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХ АРГАЧЛАЛ

2.1. Зорилго

Эдийн засаг, нийгмийн аливаа салбараас боловсруулж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн хүрээнд дэвшүүлж буй бодлогын зорилтуудыг Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилго, зорилтуудтай уялдуулахад энэхүү арга хэрэгслийн зорилго оршино.

2.2. Хамрах хүрээ

Энэхүү арга хэрэгслийг дараах зориулалтаар ашиглана. Үүнд,

- Хүчин төгөлдөр хэрэгжиж буй бодлогын хэрэгжилтийг үнэлэх бус, харин эдийн засаг, нийгмийн аливаа салбараас боловсруулж буй хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах үйл явцад буюу тэдгээрийн дэвшүүлж буй бодлогын зорилтод дүн шинжилгээ хийхэд ашиглана.
- 48 шалгуур асултыг Тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилго, зорилтын үндэсний шалгуур үзүүлэлтийн төсөлд үндэслэн боловсруулсан болно.
- Аливаа бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилго, зорилтын чанар, томъёололд үнэлгээ, дүгнэлт өгөхөд зориулагдаагүй болно.
- Эдийн засаг, нийгмийн аливаа салбарын хүрээнд дэвшүүлж буй хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн зорилтууд нь Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилго, зорилтуудтай хэрхэн уялдаж байгаа болон тэдгээр байгаль орчны зорилтуудыг хэрэгжүүлэхэд эерэг эсвэл сөрөг нөлөөтэй эсэхийг асуулгын дагуу оноогоор үнэлж, чанарын шинжилгээ хийхэд зориулагдсан.
- Төрийн болон төрийн бус аливаа байгууллага хэрэглэх боломжтой.

2.3. Зарчим

Энэхүү арга хэрэгсэл (tool)-ийг ашиглан чанарын шинжилгээ хийхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Тухайн бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилтыг аль болох бодит агуулгаар нь авч үзэх;
- Шинжилгээнд бодит нөхцөл байдлыг тусгах;
- Чанарын шинжилгээг олон талын оролцоог ханган хийх бөгөөд төрийн болон төрийн бус (хувийн хэвшил, холбоо, иргэний нийгэм, эрдэм шинжилгээ, судалгааны зэрэг) байгууллагын харьцаа 1:2 байх;
- Оролцогч талууд зөвшилцөн нэгдсэн байр суурьд хүрсэн тохиолдолд чанарын шинжилгээний үр дүнг баталгаажуулах.

2.4. Арга хэрэгсэл (tool)-ийг ашиглах заавар

Арга хэрэгсэл нь Зураг 1-т заасны дагуу 7 талбараас бүрдэнэ.

Зураг 1. Арга хэрэгслийн бүрэлдэхүүн

№	ТХЗ-ын зорилт	Асуулт	Талбар 3 Бодлогын баримт бичгийн төсөл дэх бодлогын зорилт								Нийлбэр оноо
			1	2	3	4	5	...	N		
1	2.4	Асуулт 1									
2	2.5	Асуулт 2									
3	3.9	Асуулт 3									
4	4.7	Асуулт 5									
5	6.1	Асуулт 6									
48	15.с	Асуулт									
Нийлбэр оноо											Бүгд оноо

Талбар 1 → Эхний багана дэс дугаар, 2 дахь багана Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтуудын дугаарыг харуулна.

Талбар 2 → Чанарын шинжилгээ хийхэд ашиглах 48 шалгуур асуултыг жагсаан бичнэ. Эдгээр асуултыг Тогтвортой хөгжлийн 6, 12, 13, 15 дугаар зорилго болон бусад холбогдох ТХЗ-ын зорилго болон ТХЗ-ын зорилтын үндэсний шалгуур үзүүлэлтийн төсөлд үндэслэн боловсруулсан болно.

Талбар 3 → Эдийн засаг, нийгмийн аливаа салбараас боловсруулж буй хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн зорилтуудыг дугаарлан хэвтээ мөрөнд бичнэ. Бодлогын зорилт бүр Талбар 2 дахь 48 шалгуур асуулт бүрээр асуугдаж, хариулах замаар аргачлалын дагуу чанарын шинжилгээ хийж оноогоор үнэлнэ. Ингэснээр тухайн төслийн бодлогын зорилт нь Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилго, зорилттой хэрхэн нийцэж байгаад үнэлгээ өгөх, цаашлаад сайжруулах, уялдуулах боломж бүрдэх юм.

Талбар 4 → Бодлогын зорилтыг оноогоор үнэлэх замаар чанарын шинжилгээ хийх талбар. Эдгээр нүдэнд чанарын оноо (тоо) бичигдэнэ. Чанарын оноо өгөх арга, тайлбарыг Хүснэгт 1-д харуулсан болно.

Талбар 5 → Хэвтээ тэнхлэгийн дагуух чанарын онооны нийлбэрийг харуулна. Уг оноо нь бодлогын баримт бичгийн төсөл дэх зорилт тус бүр нь ТХЗ-ын аливаа зорилтод нийцэж байгаа эсэхийг харуулна.

Талбар 6 → Босоо тэнхлэгийн дагуух чанарын онооны нийлбэр оноог харуулна. Уг оноо нь бодлогын баримт бичгийн төсөл дэх аливаа зорилт нь ТХЗ-ын зорилтуудтай хэрхэн уялдаж байгааг харуулна.

Талбар 7 → Хэвтээ болон босоо тэнхлэгийн дагуух нийлбэр онооны дүн буюу матрицийн бүгд оноог харуулна. Бүгд оноо нь Талбар 4-т бөглөгдсөн чанарын онооны баланс-нийлбэр юм. Уг бүгд оноонд тулгуурлан бодлогын баримт бичгийн төсөл нь бүхэлдээ Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилго, зорилтуудтай хэрхэн нийцэж, эс нийцэж байгаад үнэлгээ өгнө.

2.5. Чанарын оноо өгөх заавар


Бодлогын зорилт бүрд тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой 48 шалгуур асуултын дагуу чанарын оноо өгөн, нөлөөлөх байдлыг тогтоохдоо Хүснэгт 1-ийг ашиглана. Ингэхдээ -2, -1, 0, 1, 2 гэсэн 5 шатлалтай онооноос аль тохирохыг нь өгөх бөгөөд холбогдох тайлбарыг харуулав.

Хүснэгт 1. Онооны тайлбар

Чанарын оноо	Тайлбар	
+2	Шууд эерэг нөлөөтэй	Асуулгын дагуу бодлогын зорилт нь Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтод эерэгээр шууд нөлөөлөх бол "+2" өгнө.
+1	Дам эерэг нөлөөтэй	Асуулгын дагуу бодлогын зорилт нь Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтод эерэгээр дам байдлаар нөлөөлөх бол "+1" оноо өгнө
0	Нөлөөгүй (хамааралгүй)	Асуулгын дагуу бодлогын зорилт нь Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтод ямар нэгэн нөлөөгүй, хамааралгүй бол "0" оноо өгнө.
-1	Дам сөрөг нөлөөтэй	Асуулгын дагуу бодлогын зорилт нь Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтод сөргөөр дам байдлаар нөлөөлөх бол "-1" оноо өгнө.
-2	Шууд сөрөг нөлөөтэй	Асуулгын дагуу бодлогын зорилт нь Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтод сөргөөр шууд нөлөөлөх бол "-2" оноо өгнө.

Тайлбар: "Асуулгаар" гэдэг нь Талбар 2-т байршуулсан Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой сонгон авсан зорилтуудад тулгуурлан тодорхойлсон 48 асуулт байна.

Зураг 2. Шинжилгээ хийх үе шат



2.6. Чанарын шинжилгээний үр дүнгийн тайлал, дүгнэлт өгөх заавар

Энэхүү арга хэрэгслийг ашиглан дараах 3 түвшинд чанарын үнэлгээг хийх бөгөөд үнэлгээ тус бүр Тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилтууд нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлтэй хэрхэн уялдаж байгаа байдалд чанарын шинжилгээ хийх боломж олгоно.

1. Зураг 1-ийн Талбар 5-д гарсан Нийлбэр онооны тайлал

Энэхүү нийлбэр оноо нь Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтын агуулгаар бэлтгэсэн 48 шалгуур асуулт бүрийн мөрийн дагуух онооны нийлбэр дүн юм. Уг оноо нь бодлогын баримт бичгийн төсөл дэх зорилт тус бүр нь ТХЗ-ын аливаа зорилтод нийцэж байгаа эсэхийг харуулна.

Хүснэгт 2. Талбар 5-д гарсан Нийлбэр онооны тайлал хийх, дүгнэлт өгөх заавар

Хэвтээ тэнхлэгийн Нийлбэр онооны дүн	Үр дүнд тайлал хийх, дүгнэлт өгөх заавар
“Эерэг” утгатай гарсан бол	Шалгуур асуултаар илэрхийлэгдэх Тогтвортой хөгжлийн байгаль орчны тухайн зорилт нь агуулгын хувьд бодлогын баримт бичгийн ихэнх зорилттой УЯЛДАЖ БАЙНА гэсэн гаргалгааг хийж болно. Нийлбэр дүн эерэг гарсан хэдий ч аль нэг бодлогын зорилт сөрөг утга авсан бол тухайн бодлогын зорилтыг холбогдох Тогтвортой хөгжлийн зорилгын зорилттой УЯЛДУУЛАН САЙЖРУУЛАХ нь зүйтэй юм.
“0” утгатай гарсан бол	Тухайн асуултын хувьд сөрөг утга авсан бодлогын зорилтыг холбогдох Тогтвортой хөгжлийн зорилттой УЯЛДУУЛАН САЙЖРУУЛАХ нь зүйтэй юм.
Бүх утга нь “0” бөгөөд нийлбэр дүн нь “0” бол	Бодлогын баримт бичгийн төслийн хүрээнд дэвшүүлж буй бодлогын зорилт бүрийн утга “0” буюу нийлбэр оноо нь “0” утгатай гарсан. Энэ тохиолдолд, тухайн шалгуур асуултаар илэрхийлэгдэх Тогтвортой хөгжлийн тухайн зорилтын гол агуулга (санаа) нь тухайн бодлогын зорилтуудад ямар нэгэн нөлөөгүй буюу ХАМААРАЛГҮЙ гэж үзнэ.
“Сөрөг” утгатай гарсан бол	Бодлогын баримт бичгийн төслийн ихэнх зорилтууд нь Тогтвортой хөгжлийн зорилтод сөрөг нөлөө үзүүлэхээр байна. Энэ тохиолдолд, тухайн бодлогын зорилтыг ЭРГЭН ХАРЖ, НИЙЦҮҮЛЭН ЗАСВАРЛАХ ШААРДЛАГАТАЙ гэсэн гаргалгааг хийнэ.

2. Зураг 1-ийн Талбар 6-д гарсан нийлбэр онооны тайлал

Энэхүү нийлбэр оноо нь бодлогын баримт бичгийн төслийн зорилт бүрийн баганын дагуух онооны нийлбэр дүн юм. Уг оноо нь бодлогын баримт бичгийн төсөл дэх аливаа зорилт нь ТХЗ-ын зорилтуудтай хэрхэн уялдаж байгааг харуулна.

Хүснэгт 3. Босоо тэнхлэгийн нийлбэр онооны тайлал хийх, дүгнэлт өгөх заавар (Талбар 6)

Нийлбэр онооны дүн	Үр дүнд тайлал хийх, дүгнэлт өгөх заавар
“Эерэг” утгатай гарсан бол	Бодлогын тухайн зорилт Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтод эерэг нөлөө үзүүлэхээр томъёологдсон (төлөвлөгдсөн) байна. Энэ тохиолдолд, тухайн бодлогын зорилт нь Тогтвортой хөгжлийн зорилттой УЯЛДАЖ БАЙНА гэсэн гаргалгааг хийнэ. Хэдийгээр нийлбэр дүн эерэг гарсан ч аль нэг асуултын хувьд сөрөг утга авсан бол бодлогын зорилтыг Тогтвортой хөгжлийн зорилттой УЯЛДУУЛАН САЙЖРУУЛАХ нь зүйтэй юм.
“0” утгатай гарсан бол	Сөрөг утга авсан бодлогын зорилтыг асуулгын дагуух Тогтвортой хөгжлийн зорилттой УЯЛДУУЛАН САЙЖРУУЛАХ нь зүйтэй юм.
Бүх утга нь “0” бөгөөд нийлбэр дүн нь “0” бол	Бодлогын баримт бичгийн зорилт нь Тогтвортой хөгжлийн зорилтуудтай ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй буюу ХАМААРАЛГҮЙ гэж үзнэ.

“Сөрөг” утгатай гарсан бол	Тухайн бодлогын зорилт Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтуудад сөрөг нөлөө үзүүлэхээр томьёологдсон (төлөвлөгдсөн) байна. Энэ тохиолдолд, сөрөг үнэлгээ авсан бодлогын зорилтуудыг Тогтвортой хөгжлийн зорилттой уялдахгүй байна гэж үзээд ЭРГЭН ХАРЖ, НИЙЦҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ гэсэн гаргалгааг хийнэ.
-----------------------------------	--

3. Зураг 1-ийн Талбар 7-д гарсан БҮГД ОНОО-ны тайлал

Бүгд оноог тухайн хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг бүхэлд нь үнэлж, дүгнэлт өгөхөд ашиглана. Бүгд оноо нь Талбар 5 болон Талбар 6-ийн нийлбэр дүн юм.

Хүснэгт 4. Бүгд онооны тайлал хийх, дүгнэлт өгөх заавар (Талбар 7)

Талбар 5-ын Бүгд онооны дүн	Үр дүнд тайлал хийх, дүгнэлт өгөх заавар
“Эерэг” утгатай гарсан бол	Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн хүрээнд дэвшүүлсэн бодлогын зорилтуудыг 48 шалгуур асуулт бүрээр асуух замаар чанарын оноо өгч, нэгдсэн Бүгд оноо нь “Эерэг” утгатай гарсан. Жишээ нь: “+25”. Эндээс дүгнэж үзэхэд, тухайн хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл нь Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтуудыг хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Энэ тохиолдолд, тухайн бодлогын баримт бичгийн төсөл нь Тогтвортой хөгжлийн зорилтуудтай УЯЛДАЖ байна гэсэн гаргалгааг хийнэ.
“0” утгатай гарсан бол	Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн хүрээнд дэвшүүлсэн бодлогын зорилтуудыг 48 шалгуур бүрээг асуух замаар чанарын оноо өгч, нэгдсэн Бүгд оноо нь “0” утгатай гарсан. Эндээс дүгнэж үзэхэд, хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн хүрээнд дэвшүүлсэн бодлогын зорилтуудын тал хувь (эсвэл огт хамааралгүй) нь Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтуудыг хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлж, үлдсэн хэсэг нь сөрөг нөлөө үзүүлэхээр байна. Энэ тохиолдолд, сөрөг үнэлгээ авсан бодлогын зорилтуудыг Тогтвортой хөгжлийн зорилтуудтай УЯЛДУУЛАХ ШААРДЛАГАТАЙ гэсэн гаргалгааг хийнэ.
“Сөрөг” утгатай гарсан бол	Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн хүрээнд дэвшүүлсэн бодлогын зорилтуудыг 48 шалгуур асуулт бүрээр асуух замаар чанарын оноо өгч, нэгдсэн Бүгд оноо нь “Сөрөг” утгатай гарсан. Жишээ: “- 25”. Эндээс дүгнэж үзэхэд, тухайн хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл нь ерөнхийдөө Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтуудыг хэрэгжүүлэхэд сөрөг нөлөө үзүүлэхээр байна. Энэ тохиолдолд, тухайн бодлогын баримт бичгийн төсөл нь бүхэлдээ Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой зорилтуудтай УЯЛДАХГҮЙ байна гэж үзээд ЭРГЭН ХАРЖ, НИЙЦҮҮЛЭН ЗАСВАРЛАХ ШААРДЛАГАТАЙ гэсэн гаргалгааг хийнэ.

2.7. ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГОД ХИЙСЭН ТУРШИЛТЫН ШИНЖИЛГЭЭ

Дээр дурдсан аргачлалын хэрэглээг харуулах зорилгоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй «Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого»-д олон талын оролцоотойгоор дүн шинжилгээ хийснийг дараах зурагт харуулав. Зурагт тусгагдсан оноо болон дүгнэлт нь Засгийн газрын албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

Энэхүү аргачлалд заасны дагуу «Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого»-ын 27 зорилтыг дээр дурдсан 48 шалгуур асуултын дагуу байгаль орчны Тогтвортой хөгжлийн зорилттой нийцтэй эсэхийг оноогоор үнэлж зорилт тус бүрийн харгалзах нүдэнд үнэлгээний оноог бичсэн болно. Байгаль орчны хүчин зүйлүүдэд харгалзах мөрний бүх нүдэнд «0» гэсэн оноотой мөрнүүд буюу хамааралгүй хэсгийг хасч харуулав. Хэвтээ болон босоо тэнхлэгийн дагуух нийлбэр онооноос энд зөвхөн зарим нүдэн дэхь оноог тайлбарлав. Шар өнгөөр тодруулсан дугаарууд (1-8) нь шинжилгээний аль нэг хэсгийн дүнг тайлбарлах бөгөөд удаах тоон утгууд нь тайлбарлаж буй чанарын онооны утга болно. Эцэст нь цагаан өнгөөр тодруулсан цэнхэр оноо нь бодлогын баримт бичгийн үнэлгээний бүгд оноо юм.

ТӨРӨӨС ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ХИЙСЭН ТУРШИЛТЫН ШИНЖИЛГЭЭ

№	№PS	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	Индикатор ондоо
3	3.9	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
5	6.1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
6	6.2	2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
10	6.6	2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
13	7.1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
14	7.2	-2	-2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
15	7.3	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
17	9.4	-2	-2	-1	-2	-1	-1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
18	11.3	-2	-2	1	-2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
19	11.4	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	
20	11.6	-2	-2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
22	11.1	-1	-2	1	-2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
24	12.1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
25	12.2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
27	12.4	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
28	12.5	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
30	12.7	-2	-2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
32	12.9	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
33	12.6	-1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
35	14.4	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	
37	15.1	-1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
38	15.3	-1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
40	15.4	-1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
41	15.5	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-2	
Индикатор ондоо		-12	-12	7	0	5	7	-1	0	8	0	0	0	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	

Энэ нь Тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцэж байна, гэхдээ зарим зорилтуудыг эргэж хянах!

1  Шүүд эерэг нөлөө

3.1.6. Цахилгаан, Дулаан дамжуулах, Түгээх сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагааг дээшлүүлэх, хэрэглэгчид хүргэх эрчим хүчний чанарыг сайжруулах
6.1. Балалгаат үндны усаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?

2  Шүүд бус эерэг нөлөө

3.2.3. Монгол орны говийн бүсийн нэр, салхины арвин нөөцөд тулгуурлан том чадлын сэргээгдэх эрчим хүчний цогцлолбороос Эүүн хойд. Азийн орнуудад цахилгаан экспортолох Гобитек-Азийн нэгдсэн сүлжээ санаачилгыг хэрэгжүүлэхэд бус нутгийн орнуудтай хамтран ажиллах
11.А. Тогтвортой, мөсгөн хот, суурин газар амьдарч байгаа хүн амын тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?

3  Шүүд бус серег нөлөө

3.1.6. Цахилгаан, Дулаан, Дамжуулах, Түгээх сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагааг дээшлүүлэх, хэрэглэгчид хүргэх эрчим хүчний чанарыг сайжруулах
11.Б.Хот, суурин газрын орчны бохирдлыг (газар, ус, хөрс) бууруулахад ямар нөлөө үзүүлэх вэ?

4  Шүүд серег нөлөө


3.1.1. Анхдагч эрчим хүч, Тулшийн хангалжийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх
9.4. ДНБ-д ногдох нурстөрөгчийн ялгарлын хэмжээг бууруулахад ямар нөлөө үзүүлэх вэ?

5  Шүүд серег нөлөө

3.1.1-р зорилт нь Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой хэрэгжүүлэхэд эрэг нөлөө үзүүлэхээр төмөрбологдсон байна.

6  Шүүд серег нөлөө

3.6.5-р зорилт нь Тогтвортой хөгжлийн байгаль орчинтой холбоотой хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхээр төмөрбологдсон байна.

7  Шүүд серег нөлөө

7.1. Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?

ТХЗ-ын 7.1-ийн хувьд эрчим хүчний бодлогын ихэнх зорилтууд эергээр тусган авч, нөлөөлж байна.

8  Шүүд серег нөлөө

15.4. Өндөр Уулын бүсийн Энхисүмийг ТХЗ-ын 15.4-ийн хувьд хамгаалахад эрчим хүчний бодлогын зорилтууд нь сергээр тусган авсан буюу эерчилж байна.

8  Шүүд серег нөлөө

15.4. Өндөр Уулын бүсийн Энхисүмийг ТХЗ-ын 15.4-ийн хувьд хамгаалахад эрчим хүчний бодлогын зорилтууд нь сергээр тусган авсан буюу эерчилж байна.

Хавсралт. Арга хэрэгсэлд тусгагдсан 48 асуулт дэх ТХЗ-ын тұлхуур үг, ойлголтын тайлбар

№	ТХЗ-ын зорилтын дугаар	Тогтвортой хөгжлийн зорилт (олон улсын түвшинд тодорхойлсон)	ТХЗ-ын үндэсний түвшинд тодорхойлсон шалгуур үзүүлэлт (төсөл)	АСУУЛТ	Түлхүүр үг, ойлголтын тайлбар
1	2.4	Зорилт 2.4 2030 он гэхэд хүнс үйлдвэрлэлийн тогтвортой системийг бий болгож, бүтээмж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экосистемийн тэнцвэрийг хангаж чадах, цаг уурын өөрчлөлт, эрс тэс цаг агаар, ган зуд, үер, бусад гамшигт үзэгдэлд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх, газар хөрсний чанарыг тасралтгүй сайжруулах хөдөө аж ахуйн уян хатан арга туршлагыг нэвтрүүлэх	ТХЗ-ын үндэсний түвшинд тодорхойлсон шалгуур үзүүлэлт (төсөл) 2.4.1. Бүтээмжтэй, тогтвортой хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд ашиглагддаг хөдөө аж ахуйн газар нутгийн эзлэх хувь	Бүтээмжтэй, тогтвортой хөдөө аж ахуйн газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	Бүтээмжтэй, тогтвортой хөдөө аж ахуйн газар гэдэг нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, экологийн хувьд сөрөг нөлөөгүй, эдийн засгийн үр ашгийг тариалангийн үйлдвэрлэлийг дэмжиж, нэгж талбайгаас авах урсгацын хэмжээг нэмэгдүүлэх тухай бөгөөд Монгол орны байгаль, цаг уур, хөрсний нөхцөлд тохирсон тариалангийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх, үр сөрг, үрийн аж ахуйн тогтлооцоог сэргээж өгжүүлэх, үрийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээс хангах тухай ойлголт юм. УИХ-ын 2003 оны 29 дүгээр тогтоолоор баталсан Хүнс, хөдөө төрөөс аж ахуйн талаар баримтлах бодлого. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/11485
2	2.5	Зорилт 2.5 2030 он гэхэд олон улс, бус нутаг, үндэсний түвшний зохистой удирдлага, зохион байгуулалттай, олон төрлийн үр, ургамлын сантай банкаар дамжуулан үр, тариалах ургамал, фермерийн болон гэрийн тэжээвэр амьтан, тэдгэртэй холбоотой зэрлэг ан амьтдын генетикийн олон янз байдлыг хадгалж, олон улсын хэмжээнд тохиролцсоны дагуу генетикийн нөөц баялаг, уламжлалт холбогдох мэдлэгийг ашигласнаар гарах үр шимийг хүртэх, эрх тэгш, шударга зарчмаар солилцох нөхцөлийг бүрдүүлэх	2.5.1. Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр ашиглахаар дунд болон урт хугацаанд зориулалтын хадгалалтын байгууламжид байсан ургамал, амьтны генетикийн нөөцийн хэмжээ 2.5.2. Устах эрсдэлтэй нутгийн үүлдрийн малын тоо	Устах эрсдэлтэй нутгийн үүлдрийн цөм сүргийг өсгөж, үржлийн чанарыг сайжруулахад ямар нөлөө үзүүлэх вэ?	Нутгийн үүлдрийн цөм сүргийг тухай ойлголт. Малыг генетик нөөцийн тухай хуульд 4.1.7-д "цөм сүрэг" гэж тухайн үүлдэр, омгоос ашиг шимийн хэмжээ, чанараар давуу хэсгийг сонгон үржүүлж байгаа сүрэг малыг хэлнэ гэж заасан. Манай оронд байгалийн шалгарал, малчид, мэргэжилтнүүдийн уйгагүй зүтгэл, бүтээлч хөдөлмөр, шинжлэх ухааны үндэслэлтэй сонгон үржүүлгийн ажлын үр дүнд, бий болсон 40 гаруй үүлдэр, үүлдрийн хэсэг, омог, хэвшлийн малын генетик нөөц байна. Эдгээр малын генетик нөөц нь нутгийн үүлдрийн цөм сүргийг бүрдүүлдэг. УИХ-ын 2003 оны 29 дүгээр тогтоолоор баталсан Хүнс, хөдөө төрөөс аж ахуйн талаар баримтлах бодлогын 5.4-д "нутгийн шилдэг омог, үүлдрийн цөм сүрэг, гадаадын арвин ашиг шимт мал, амьтны шалгарсан удмыг сайжруулагчаар ашиглах, биотехнолог, генийн инженерчлэлийн дэвшилт аргыг нэвтрүүлэх замаар малын үүлдэрлэлт байдлыг сайжруулах" зорилтыг, мөн УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол мал" Үндэсний хөтөлбөрт "3.2.1.1.Бэлчээрийн монгол малыг тухайн орон нутагт зохисон ашиг шимийн чиглэлийн үүлдэр, омог, хэвшлийн цөм сүргийн малаар сайжруулах: 3.2.2.2 тоо нь цөөрч, удмын сан нь алдагдахад хүрч байгаа үүлдэр, омгийн болон гойд ашиг шимт малын удмын санг хамгаалах, зохистой ашиглах, үрийн нөөцтэй болох ажлыг зохион байгуулах," гэсэн цөм сүрэг, малын удмын сантай холбоотой зорилтуудыг дэвшүүлсэн байдаг. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/13051 , https://www.legalinfo.mn/law/details/3340?lawid=7039

3	3.9	Зорилт 3.9 2030 он гэхэд аюултай химийн бодис, агаар, ус, хөрсний бохирдол, халдвараас болж үхсэн, өвдсэн хүмүүсийн тоог үлэмж хэмжээгээр бууруулах	3.9.1. Дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоор нөхцөлсөн нас баралтын түвшин (10 000 хүн амд ногдох) 3.9.2. Баталгаагүй үндны ус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжаар нөхцөлсөн нас баралтын түвшин (10 000 хүн амд ногдох) 3.9.3 Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин (10 000 хүн амд ногдох)	<p>Аюултай химийн бодис, агаар, ус, хөрсний бохирдол, халдвараас шалтгаалсан өвчлөлт, нас баралтыг бууруулахад ямар нөлөө үзүүлэх вэ?</p> <p>Аюултай химийн бодис, аюултай хог хаягдлын тухай ойлголт. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд "химийн хорт бодис" гэж хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй химийн бодис, тэдгээрийн нэгдлийг, харин "химийн аюултай бодис" гэж зэрэгтэйг, шатамхай, идэмхий, исэлдүүлэгч, цочромтгой шинж чанартай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг хэлнэ. Хог хаягдлын тухай хуульд "аюултай хог хаягдал" гэж тэсэрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг ойлгоно.</p> <p>Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/526, https://www.legalinfo.mn/law/details/12652</p>	<p>Тогтвортой хөгжлийн боловсролын тухай ойлголт. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиуд болон их дээд сургуулиуд боловсролын байгууллагууд нь хүүхэд залуучуудыг хариуцлагагай, дэлхийн иргэн болгон төлөвшүүлэх, хамтран аж төрөх, хамтран ажиллах, суралцахад сургах, уур амьсгалын өөрчлөлт зэрэг глобал асуудлуудыг хамтдаа шийдэхэд сургахад чиглэн ажиллах хэрэгтэй бөгөөд Тогтвортой хөгжлийн боловсрол нь тогтвортой хөгжлийн үндэс гэж үздэг тул боловсролын чанарыг сайжруулахад чиглэгдэнэ. Мөн тогтвортой хөгжлийн боловсрол нь хүрээлэн буй орчны асуудал болох ус, уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон төрөл зүйл, тогтвортой үйлдвэрлэл болон хэрэглээгээр хязгаарлагдах бус ядууралтай тэмцэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, нийгмийн өөрчлөлтийн удирдлага зэрэг хөгжлийн эдийн засгийн асуудлууд болон соёлын олон төрөл зүйлийг хамгаалан авч үлдэх, жендерийн эрх тэгш байдлыг хангах, ДОХ-той тэмцэх, ард түмний уламжлалт зан үйлийг хамгаалах зэрэг нийгмийн асуудлуудыг ч хамардаг юм.</p> <p>Эх сурвалж: http://www.unesco.org/education/tefl/mn/p/47</p>
4	4.7	Зорилт 4.7 2030 он гэхэд тогтвортой хөгжлийн мэдлэг, тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендерийн тэгш байдал, энх тайван болон хүч үл хэрэглэх соёлыг төлөвшүүлэх, дэлхийн иргэн байх, соёлын олон янз байдал болон тогтвортой хөгжилд соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгуулах мэдүүлэх замаар тогтвортой хөгжлийг хөгжүүлэх дэмжихэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бүх суралцагчдад олгох	<p>Бүх шатны боловсролын тогтолцоонд тогтвортой хөгжлийн боловсролыг тусгахад ямар нөлөө үзүүлэх вэ?</p>	<p>Тогтвортой хөгжлийн боловсролын тухай ойлголт. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиуд болон их дээд сургуулиуд боловсролын байгууллагууд нь хүүхэд залуучуудыг хариуцлагагай, дэлхийн иргэн болгон төлөвшүүлэх, хамтран аж төрөх, хамтран ажиллах, суралцахад сургах, уур амьсгалын өөрчлөлт зэрэг глобал асуудлуудыг хамтдаа шийдэхэд сургахад чиглэн ажиллах хэрэгтэй бөгөөд Тогтвортой хөгжлийн боловсрол нь тогтвортой хөгжлийн үндэс гэж үздэг тул боловсролын чанарыг сайжруулахад чиглэгдэнэ. Мөн тогтвортой хөгжлийн боловсрол нь хүрээлэн буй орчны асуудал болох ус, уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон төрөл зүйл, тогтвортой үйлдвэрлэл болон хэрэглээгээр хязгаарлагдах бус ядууралтай тэмцэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, нийгмийн өөрчлөлтийн удирдлага зэрэг хөгжлийн эдийн засгийн асуудлууд болон соёлын олон төрөл зүйлийг хамгаалан авч үлдэх, жендерийн эрх тэгш байдлыг хангах, ДОХ-той тэмцэх, ард түмний уламжлалт зан үйлийг хамгаалах зэрэг нийгмийн асуудлуудыг ч хамардаг юм.</p> <p>Эх сурвалж: http://www.unesco.org/education/tefl/mn/p/47</p>	
5	6.1	Зорилт 6.1 2030 он гэхэд хүн бүрийг үндны аюулгүй, боломжийн үнэтэй усаар хангах	<p>Баталгаат үндны усаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?</p>	<p>Баталгаат үндны усны тухай ойлголт. Усны чанар, нэр томъёоны тодорхойлолт MNS 6279 : 2011 Стандартад "үндны ус" гэдэг нь хүн ам хүнсний зориулалтаар хэрэглэх, эрүүл ахуйн шаардлага хангасан стандартад нийцсэн усыг хэлнэ. "Баталгаат" гэдгийг мөн MNS 6279 : 2011 стандартаар тодорхойлж өгсөн. Эх сурвалж: https://www.unpd.org/content/dam/mongolia/Publications/Environment/RuralWaterProject/tol_mercy.pdf</p>	

6	6.2	Зорилт 6.2 2030 он гэхэд хүн бүрийн тэтгэл хүртээмжтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжид хамруулж, охид, эмэгтэчүүд, эмзэг бүлгийнхний хэрэгцээ шаардлагыг онцгойлон анхааран үзэж ил задгай биеэ засах явдлыг зогсоох	6.2.1. Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн үйлчилгээгээр хангагдсан хүн амын эзлэх хувь (гар угаах саван, ус, угаалтуурыг хамруулна)	Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	<p>Ариун цэврийн байгууламж тухай ойлголт. Ариун цэврийн байгууламж гэдгийг хүрээнд "эриутгах татуурга", "шугам сүлжээ", "бохир усны гаргалгааны шугам", "бохир ус цуглуулах шугам", "цэвэрлэх байгууламж", "гэсэн бохир ус татан зайлуулах шугам", "цэвэрлэх байгууламж" гэсэн бохир ус татан зайлуулах, ариун цэврийн байгууламжтай холбоотой ойлголтуудыг хамруулна. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 3.1.3-д "эриутгах татуурга" гэж хэрэглэнээс гарсан бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламж, бохир усны цооногийг; 3.1.5-д "шугам сүлжээ" гэж цэвэр ус дамжуулах, түгээх, хэрэглэнээс гарсан бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, хэрэглэнээс гарсан бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, түгээх, хэрэглэнээс гарсан бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах байгууламжийг; 3.1.8-д "бохир усны гаргалгааны шугам" гэж хэрэглэнээс гарсан санхүүжлийн хэрэгцээс барилгын гадна талын эхний худад хүртэлх шугам сүлжээг; 3.1.9-д "бохир ус цуглуулах шугам" гэж барилгын гадна талын эхний худад бохир ус татан зайлуулах шугамд холбогдож байгаа худад хүртэлх шугам сүлжээг; 3.1.10-д "бохир ус татан зайлуулах шугам" гэж бохир ус цуглуулах шугамд холбогдож байгаа эхний худгаас бохир ус цэвэрлэх байгууламжийн хүлээн авах сан хүртэлх шугам сүлжээг; 3.1.11-д цэвэрлэх байгууламж" гэж бохир ус татан зайлуулах шугамаас бохир усгй хүлээн авч цэвэрлэх цогц байгууламжийг; тус тус тодорхойлсон. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/531</p> <p>Мөн Усны чанар, нэр томьёоны тодорхойлолт MNS 6279 : 2011 Стандартад "Ариун цэврийн байгууламж", "бохир усны гаргалгааны шугам", "бохир ус цуглуулах шугам", "бохир ус татан зайлуулах шугам" тайлбарлаж өгсөн. Эх сурвалж: https://www.undp.org/content/dam/mongolia/Publications/Environment/RuralWaterProject/loiL_mercy.pdf</p>
7	6.3	Зорилт 6.3 2030 он гэхэд дэлхийн түвшинд бохирдлыг бууруулах, хог хаях ажиллагааг халах, аюултай химийн бодис, материалыг гаргах явдлыг хамгийн бага түвшинд хүргэх, цэвэрлэгдээгүй бохир ус хувь хэмжээг хоёр дахин бууруулах, усыг дахин боловсруулж, цэвэршүүлэн хэрэглэх явдлыг [x] хувиар нэмэгдүүлэх замаар усны чанарыг сайжруулах	6.3.1 Цэвэрлэх байгууламжаар дамжуулан цэвэрлэсэн хаягдал бохир усны эзлэх хувь	Хаягдал усыг цэвэрлэж, дахин болон эргүүлэн ашиглах усны хэмжээг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	<p>Хаягдал ус гэдэг нь Усны тухай хуулийн 3.1.24-д ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээгээр гарч байгаа бохир ус, шингэн хаягдлыг ойлгоно. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/531</p> <p>Усыг дахин болон эргүүлэх ашиглах тухай ойлголт. Усыг дахин ашиглах (Reuse of water) гэдэг нь усыг аливаа нэг ашиглалтаас гарч буй хаягдал усыг техникийн хэрэгцээ, газар тариалангийн усалгаа зэрэгт дагтан ашиглахаар авах арга хэмжээг хэлнэ. Өөрөөр хэлбэл, Тухайн ашигласан хаягдал усыг өөр зориулалтаар ашиглах арга хэмжээ юм. Харин эргүүлэн ашиглах гэдэг нь тухайн ашигласан усыг тухайн зориулалтаар эргүүлэн ашиглах арга хэмжээг хэлнэ. Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн нэр томьёоны тайлбар толь. Монгол улсын Засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтарсан "Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах" МОН/08/302 төсөл. Эх сурвалж: https://www.undp.org/content/dam/mongolia/Publications/Environment/RuralWaterProject/loiL_mercy.pdf</p>
8	6.4	Зорилт 6.4 2030 он гэхэд бүх салбарт усны хэрэглээний үр ашгийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, усны хомсдолоос гаргах үүднээс цэвэр усны тогтвортой олборлолт, хангамжийг хангаж, усны хомсдолоос өртсөн хүн амын тоог үлэмж хэмжээгээр бууруулах	6.4.1 Цаг хугацааны явцад гарсан ус хэрэглээний үр ашгийн өөрчлөлт	Усны хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	<p>Усны хэрэглээний үр ашгийн тухай ойлголт. Усны нөөц, ус ашиглалт, хангамжлалтын тухай нэр томьёоны тодорхойлолт MNS: 0000 2016 стандартад Усны хэрэглээ (Water consumption) гэдэг нь усны эх үүсвэрт буцаахгүй хэрэглэдэг усыг хэлдэг. Эх сурвалж: Стандартчилал, хэмжилзүйн газар. https://masm.gov.mn/masmi/</p> <p>Ус хэрэглээний үр ашиг (water efficiency) гэдэг нь нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулагдсан усны хэмжээг бууруулах тухай ойлголт юм. Ус хэрэглээний үр ашиг нь усны хэмнэлтэй ижил ойлголт юм. Жишээлбэл, нэг талх үйлдвэрлэхэд 0.5л ус зарцуулагддаг бол түүнийг 0.3л болгож бууруулах тухай юм.</p>

9	<p>Зорилт 6.5 2030 он гэхэд тохиромжтой гэж үзвэл хил дамнасан хамтын ажиллагаагаар дамжуулан бүх түвшинд усны нөөцийн нэгдсэн менежментийг нэвтрүүлэх</p>	<p>6.5.1 Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө (УННМТ)-ний хэрэгжилтийн түвшин (0-100)</p> <p>6.5.2 Хилийн усны гэрээ хэлэлцээрт хамрагддаг хил дамнасан усны сав газрын эзлэх хувь</p>	<p>Усны нөөцийн нэгдсэн менежмент (УННМ)-ийн төлөвлөгөөний зорилтуудад ямар нөлөө үзүүлэх вэ?</p>	<p>Усны нөөцийн нэгдсэн менежмент (УННМ)-ийн тухай ойлголт. Усны тухай хуульд "Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө" гэж сав газрын усны нөөцийг хамгаалах, зохицтой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохицуулах баримт бичгийг ойлгоно. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/8683</p> <p>УННМ-ийн тухай тухай авч үзвэл "Экосистемийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйн зэрэгцээ нийгмийн хангамж болон эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд ус болон газар, тэдгээртэй холбоотой нөөцийн нэгдсэн менежментийг сайжруулах үйл явц" юм (WWF, 2000). УННМ-ийн үндсэн шинж чанарт дараах хэмжүүрүүдийг хамааруулдаг: i) сав газрыг бүхэлд нь хамарсан асуудал, ii) ус нийгэм, эдийн засгийн сараа, үйлчилгээ болох нь, iii) усны нөөцийн тэнцвэртэй хуваарилалт, iv) усны нөөцийн нэгдсэн менежмент ба байгаль орчны менежмент, v) шинжлэх ухаанд суурилсан системийн арга зам, vi) төв/орон нутгийн захиргаа, удирдлагын хамтын ажиллагаа, vii) өртөг хэт өндөр биш, хамгийн боломжит технологи, viii) урьдчилан мэдээлэх загварчлал, борлогын дэмжлэг, ix) оролцогч талуудын оролцоо, x) хөрөнгө оруулалт, тогтвортой санхүүжүүлэх механизм. Эх сурвалж: http://www.iwgm-potom.de/iwgm_lm.htm</p> <p>Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд усны нөөцийг хамгаалж, хомслолоос сэргийлэх борлогыг Усны нөөцийн нэгдсэн менежментийн зарчмаар хэрэгжүүлэхээр тусгасан. УИХ-ын 2010 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Ус Үндэсний хөтөлбөр"-ийн 2.2.5-т "Усны нөөц, ашиглалтын менежментийг боловсронгуй болгох зорилт"-ыг дэвшүүлсэн бөгөөд Засгийн газрын 2013 оны 389 дүгээр тогтоолоор "Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө"-г баталсан. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/9687</p>
10	<p>Зорилт 6.6 2020 он гэхэд устай холбоотой экосистем, түүний дотор уул, ой, намагцсан газар, гол мөрөн, уст давхарга, нуурыг хамгаалах, сэргээх</p>	<p>6.6.1 Цаг хугацааны явцад гарсан усны экосистемийн өөрчлөлт</p>	<p>Усны эх, ой, голын татам, намагцсан газар, нуур, гол мөрөн, уст давхаргыг хамгаалах, сэргээхэд ямар нөлөө үзүүлэх вэ?</p>	<p>Голын татам (Flood plain of river) гэдэг Усны тухай хууль болон Усны нөөц, ус ашиглалт, хамгаалалтын нэр томъёоны тодорхойлолтод "голын голдирлын эргээс эхний дэнж хүртэлх нугын зурвас бүсийг" гэж тодорхойлсон. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/8683</p>
11	<p>Зорилт 6.а 2030 он гэхэд Ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой үйл ажиллагаа, хөтөлбөр, түүний дотор ус хураах, цэвэршүүлэх, усны үр ашиг, бохир усыг цэвэрлэх, дахин ашиглах технологийн чиглэлээр хөгжиж буй орнуудад үзүүлдэг олон улсын хамтын ажиллагаа, чадавх бэхжүүлэх дэмжлэг тусалцааг өргөжүүлэх</p>	<p>6.а.1 Ус хангамж, ариун цэврийн байгууламжтай холбогдох Засгийн газрын үйл ажиллагаа, хөтөлбөрт зориулсан албан ёсны хөгжлийн тусламжийн хэмжээ</p>	<p>Ус хангамж, ариун цэврийн байгууламж, ус хураах, цэвэршүүлэх, бохир усыг цэвэрлэх, усны үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой хөгжлийн тусламжийг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?</p>	

12	6.В	Зорилт 6.в Усны болон ариун цэврийн байгууламжийн менежментийг боловсронгуй болгох чиглэлээр орон нутгийн хамт олны оролцоог дэмжих, бэхжүүлэх	6.б.1 Ус хангамж, ариун цэврийн менежментэд нутгийн иргэдийн оролцоог бий болгох үйл ажиллагааны бодлого, журам бүхий орон нутгийн засаг захиргааны нэгжийн эзлэх хувь 7.1.1 Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь 7.1.2 Хийн хэрэглээ Энэ хэсгийг задаргаан дээр бичих юм байна. Евро-5 стандартын шатахууны хэрэглээ СЭХ-ний цахилгаан эрчим хүч хэрэглэгч 6%, малчин өрхийн 81.25 %	Ус хангамж болон ариун цэврийн байгууламжийн менежментийг боловсронгуй болгох чиглэлээр орон нутаг, талуудын оролцоог дэмжих, бэхжүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	
13	7.1	Зорилт 7.1 2030 он гэхэд боломжийн, найдвартай, орчин үеийн эрчим хүчний үйлчилгээгэр хүн бүрийг хангах	7.2.1 Нийт эрчим хүчний эцсийн хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 7.2.2 Нийт эрчим хүчний эзлэх хувь	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	
14	7.2	Зорилт 7.2 2030 он гэхэд дэлхийн эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх	7.2.1 Нийт эрчим хүчний эцсийн хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 7.2.2 Нийт эрчим хүчний эзлэх хувь	Эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	Сэргээгдэх эрчим хүч гэж нар, салхи, усны эрчим болон газрын гүний дулаан, биомасс зэрэг байгалийн байнга нөхөн сэргэх нөөцийг ашиглан цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх байгууламжаас үйлдвэрлэсэн цахилгаан, дулааныг хэлнэ. Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, 2007 он, Улаанбаатар. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/465
15	7.3	Зорилт 7.3 2030 он гэхэд эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийн хурдыг дэлхийн түвшинд хоёр дахин нэмэгдүүлэх	7.3.1 ДНБ, анхдагч эрчим хүчээр хэмжсэн эрчим хүчний үр ашиг	Эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	Эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийн тухай ойлголт. Эрчим хүчний үр ашиг гэж бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд ашигтай хэрэглэсэн эрчим хүчийг нийт зарцуулсан эрчим хүчинд харьцуулсан харьцааг хэлнэ. Эрчим хүч хэмнэлт гэж эрчим хүч хэмнэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний эхний болон дараах эрчим хүчний хэрэглээнд хэмжилт буюу тооцоогоор гарсан зөрүүг хэлнэ. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/11488
16	8.9	Зорилт 8.9 2030 он гэхэд ажлын байр бий болгож, орон нутгийн соёл, бүтээгдэхүүнийг дэмждэг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэн дэмжих бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх	8.9.1. Аялал жуулчлалын салбарын орлогын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 8.9.2. Нийт аялал жуулчлалын ажлын байранд тогтвортой аялал жуулчлалын салбарын ажлын байрны эзлэх хувь	Аялал жуулчлалын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	

17	9.4	Зорилт 9.4 2030 он гэхэд нөөц баялийн хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлж, цэвэр, байгальд ээлтэй технологи, үйлдвэрлэлийн ажиллагааг нэвтрүүлж, бүх улс орнууд өөрсдийн нөөц чадвархдаа уялдуулан арга хэмжээ авч хэрэгжүүлж, аж үйлдвэрийн тогтвортой ажиллагааг хангах зорилгоор дэд бүтцийг хөгжүүлж, аж үйлдвэрийг боловсронгуй болгох	9.4.1 Нэмэгдэл өртгийн нэгжид ногдох нүүрстөрөгчийн ялгарлын хэмжээ	<p align="center">ДНБ-нд ногдох нүүрстөрөгчийн ялгарлын хэмжээг бууруулахад ямар нөлөө үзүүлэх вэ?</p>	<p>Нүүрстөрөгчийн ялгарлын тухай ойлголт. Уур амьсгалын өөрчлөлтийн гол шалтгаан нь хүний үйл ажиллагааны улмаас агаар мандалд ялгарч байгаа хүлэмжийн хий юм. Хүлэмжийн хийн ялгаралтыг нүүрстөрөгчийн ялгарлын хэмжээгээр хэмждэг. Хүлэмжийн хийн ялгаралт гэдэг нь тодорхой цаг хугацаанд агаар мандалд ялгарсан нийт хүлэмжийн хийн хэмжээг хэлнэ. Хүлэмжийн хий гэж хэт улаан туяаг шингэсэн авч буцаан туяаруулах шинж чанартай байгалийн буюу хүний үйл ажиллагааны гаралтай хийн мандлын бүрэлдэхүүн хэсэг юм. Үүнд нүүрсхүчлийн хий (CO2), метан (CH4), азотын хүчил (N2O), ус фторт нүүрстөрөгчүүд (HFCs), перфторт нүүрстөрөгчүүд (PFCs), гексафторт хүхэр (SF6) зэрэг хий орно. Хүний үйл ажиллагааны улмаас агаар мандалд дахь хүлэмжийн хийн агууламж ихсэж байгаа нь орчин үеийн уур амьсгалын өөрчлөлтийн гол шалтгаан болж байна.</p> <p>Эх сурвалж: https://www.legalinfo.mn/annex/details/3357?lawid=6709, "Байгаль орчны статистик үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлал" батлах тухай Үндэсний статистикийн хорооны даргын 2019.09.16-ны өдрийн А/135 дугаар тушаал. Улаанбаатар.</p>
18	11.3	Зорилт 11.3 2030 он гэхэд бүх улс орнуудад хамтын оролцооны, нэгдсэн, тогтвортой хүн амын суурьшлын төлөвлөлт, менежментийн чадавх, бүх талын оролцоог хангасан, тогтвортой хот байгуулалтыг сайжруулах	11.3.1 Хот суурины газар ашиглалтын хувийг Хүн амын өсөлтийн хувьд харьцуулсан харьцаа 11.3.2 Хот төлөвлөлтөд иргэний нийгмийн шууд оролцоог бүрдүүлсэн, тогтмол, ардчилсан байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг удирдлага, төлөвлөлттэй хотуудын эзлэх хувь	<p align="center">Ногоон хот, суурин газрыг хөгжүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?</p>	<p>"Ногоон хот"-ын тухай ойлголт нь Тогтвортой хот байгуулалт, Тогтвортой хотын тухай ойлголтод агуулагдсан нэг юм. УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Ногоон хөгжлийн бодлого"-ын баримт бичигт "ногоон хот" гэж эрчим хүч, дулаан, ус хангамж, харилцаа холбоо, нийтийн тээврийн ухаалаг дэд бүтэц, хөгжлийн оновчтой менежмент бүхий хүний амьдралын тав тух, хөгжлийн боломжийг хангасан хот сууринг хэлнэ. Олон улсын түвшинд 2016 онд Эквадор улсын Кито хотноо Орон сууц, тогтвортой хот суурины хөгжил (ХАБИТА II) -ийн тухай НҮБ-ын Бага хурлын үеэр "Хотжилтын шинэ хөтөлбөр (The New Urban Agenda)"-ийг НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 71 дэх чуулганы 68 дугаар хуралдаанаар баталсан. Уг Хотжилтын шинэ хөтөлбөрт Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт 2030-д үндэслэн хүн амын тогтвортой нутагшилт, суурьши болон тогтвортой хотжилттой холбоотой зорилтуудыг дэвшүүлсэн байдаг.</p> <p>Эх сурвалж: https://www.legalinfo.mn/annex/details/6438?lawid=10482, http://habitat3.org/the-new-urban-agenda/</p>

19	11.4	<p>Зорилт 11.4 Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалах хамгаалах арга хэмжээг сайжруулах</p>	<p>"11.4.1. Үндэсний соёл, байгалийн өвийг хадгалах, хамгаалахад зарцуулсан нэг хүнд ногдох нийт зардлын хэмжээ (төрийн болон хувийн) өвийн төрлөөр (Дэлхийн өвийн төв байгууллагын тодорхойлсноор соёлын, байгалийн, холимог гэх зэрэг), зардлын төрлөөр (үйл ажиллагааны зардал болон хөрөнгө оруулалт), хувийн санхүүжилтийн төрлөөр (биет болон биет бус хувийн ашгийн бус байгууллагад өгч буй хандивын төрөл, ивээн тэтгэгч), засаг захиргааны нэгжийн түвшинд (ҮСХ)"</p>	<p>Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалах арга хэмжээг сайжруулах</p>	<p>Дэлхийн соёлын болон байгалийн өвийн тухай ойлголт. Соёлын өв гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чаддаг байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг хэлнэ. Соёлын биет өвд түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалыг, харин соёлын биет бус өвд хамт олон, бүлэг, хувь хүн соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан заншил, дурслах болон илэрхийлэх хэлбэр, уламжлалт мэдлэг, арга барил, тэдгээртэй холбоотой эд өлгийн зүйл, зэмсэг, урлагийн бүтээл, соёлын орон зайг ойлгоно. 2015 онд Парис хотноо ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн конвенцийн Засгийн газар хоорондын хорооны ээлжит 9 дүгээр хуралдаанаар Монгол улсын соёлын 12 өвийг ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн хүн төрөлхтний төлөөллийн жагсаалтад бүртгэн авсан. Дэлхийн байгалийн өвд Увс нуурын ай сав газар 2003 онд, Орхоны хөндийн дурсгалт газар 2004 онд, Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор 2011 онд, Их Бурхан Халдун уул, түүний эргэн тойрны ариун нандин газар 2015 онд тус тус бүртгэгдсэн. Эх сурвалж: http://www.unesco.mn/pr/144</p>
20	11.6	<p>Зорилт 11.6 2030 он гэхэд агаарын чанар, хотын болон хог хаягдлын менежментийн асуудалд онцгой анхаарлаа хандуулах замаар хотуудын нэг хүнд ногдох байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах</p>	<p>11.6.1 Хот суурин газарт тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгаж буй хог хаягдлын хувь хэмжээ (хот суурин газарт нийт үүсч буй хог хаягдалд эзлэх хувь хэмжээ 11.6.2 Хотын агаар дахь нарийн болон том ширхэглэгт тоосонцрын (өөрөөр хэлбэл, PM 2.5 болон PM 10) жилийн дундаж хэмжээ (хүн амд харьцуулсан) Улаанбаатар хотын агаар дахь PM2.5, PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж / тодорхойлсон/</p>	<p>Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалах арга хэмжээг сайжруулах</p>	<p>Хот, суурин газрын орчны бохирдлыг (агаар, ус, хөрс) бууруулахад ямар нөлөө үзүүлэх бэ?</p>

21	11.7	Зорилт 11.7. 2030 он гэхэд хүн бүрийг, ялангуяа эмэгтэйдүүд, хүүхдүүд, өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аюулгүй, бүх талын оролцоог хангасан, хүртээмжтэй, ногоон болон нийтийн зээмшлийн талбайгаар хангах	1. Нийтийн хэрэгцээний ногоон байгууламжийн хэмжээ (га) 2. Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламжийн хэмжээ (га) 3. Тусгай зориулалтын ногоон байгууламжийн хэмжээ (га) 10.7.2 Шилжин суурьших сайн бодлогыг хэрэгжүүлдэг эсэх	Нийтийн хэрэгцээний, тусгай зориулалтын ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	"Ногоон байгууламж" гэж хот, суурин хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын зураг төслийн дагуу архитектур-орон зайн тааламжтай орчин бүрдүүлэх, дуу чимээг намсгах, агаар, ус, хөрсний бохирдлыг багасгах, байгалийн тэнцэл алдагдах, гамшгаас сэргийлэх зорилгоор байгуулсан амьд мод, бут сөөг, өвслөг ургамал, цэцэг, зориулалтын барилга байгууламжийн зохицол бүхий цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, цэцэрлэгжүүлсэн гудамж, зам, талбай, биеийн тамир спорт, хүүхдийн тоглоомын талбай, ногоон зураас болон байгалийн унаган төрхийг ашиглан байгуулсан байгууламжийг хэлнэ. Эх сурвалж: "Маягт, заавар" батлах тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019.09.19-ны өдрийн А/527 дугаар ТУшаал, Улаанбаатар. "Тусгай зориулалтын" ногоон байгууламж гэдэгт эрдэм шинжилгээ, судалгааны цэцэрлэгт хүрээлэн, мод үржүүлгийн газар, үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар байгуулсан газрыг ойлгоно. Хот, суурин ногоон байгууламжийн тухай хуулийн төсөл. Эх сурвалж: https://mncud.gov.mn/resource/mncud
22	11.A	Зорилт 11.а Үндэсний болон бус нутгийн хөгжлийн төлөвлөлтийг сайжруулах замаар хот, хагас суурин газар, хөдөө орон нутгийн хооронд эдийн засаг, нийгэм, байгаль орчны үр дүнтэй уялдаа холбоо дэмжих	11.а.1 Хүн амын хэтийн тооцоо болон хэрэгцээт нөөц боломжтой уялдуулсан хот, бүсийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлдэг, хото д амьдардаг хүн амын эзлэх хувь, хотын хэмжээгээр	Тогтвортой, ногоон хот, суурин газар амьдарч байгаа хүн амын тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	
23	11.B	Зорилт 11.в 2020 он гэхэд бүх талын оролцоог хангах, хөрөнгө баялгийг үр ашгтай ашиглах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох, гамшгийг даван туулах чадварыг бэхжүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, төлөвлөгөө батлан хэрэгжүүлдэг хот, хүн амын суурьшлын тоог [х] хувьмар нэмэгдүүлж, удахгүй гарах Хёголын үйл ажиллагааны баримт бичигтэй уялдуулан бүх түвшинд гамшгийн эрсдэлийн цогц менежментийг боловсруулж, хэрэгжүүлэх	1.5.3. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг баталж, хэрэгжүүлсэн байх 1.5.4. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн стратегийг, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө баталж, хэрэгжүүлдэг орон нутгийн засаг захиргааны эзлэх хувийг нэмэгдүүлсэн байх	Хот, суурин гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зорилтуудыг хэрэгжүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	Гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зорилтуудын тухай ойлголт. Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги"-ийг баталсан. Уг стратегийн баримт бичигт гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад үе шаттай хэрэгжүүлэх Үндэсний зорилтуудыг дөвшүүлсэн. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/annex/details/8210?lawid=13125

24	12.1	Зорилт 12.1 Хөгжиж буй орнуудын хөгжил, чадаах нөөц боловсроог харгалзан үзэж хөгжингүй орнууд хошуучлан бүх улс орнууд зохих арга хэмжээ авч хэрэгжүүлж, тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн 10 жилийн хугацаатай хөтөлбөрийг хэрэгжүүлэх	12.1.1 Тогтвортой хэрэглээ Үйлдвэрлэлийн талаар үндэсний төлөвлөгөөтэй эсвэл үндэсний төлөвлөгөөндөө эдгээрийг зорилт, үндсэн чиглэл болгон тусгасан эсэх	Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжихэд ямар нөлөө үзүүлэх вэ?	Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн тухай ойлголт. Тогтвортой үйлдвэрлэл гэдэг нь байгалийн нөөц, баялгийг зохистой, үр ашгтай ашиглах, бохирдол, хаягдал багатай үйлдвэрлэл юм. Энэ нь Ногоон үйлдвэрлэл гэсэн ойлголтод агуулга ижил юм. УИХ-аар 2014 онд батлагдсан "Ногоон хөгжлийн бодлого"-ын баримт бичигт "ногоон үйлдвэрлэл" гэж эрчим хүч, нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн үийн ялгарал болон хаягдал багатай, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд эрсдэлгүй үйлдвэрлэлийн үйл ажиллагааг ойлгоно гэжээ. Засгийн газрын 2017 оны 290 Дүгээр тогтоолоор "Байгаль орчинд ээлтэй, Дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам"-ыг баталсан. Уг журмын зорилго нь Байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашгтай, зохистой ашиглах, эрчим хүчийг хэмнэх, хүлэмжийн хийн ялгарал, хог хаягдал болон дулаан алдагдлыг багасгах, агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулахад оршино. Урамшуулал нь "Ногоон гэрчилгээ", "Эко тэмдэг" олгох тухай юм. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/annex/details/6438?lawid=10482
25	12.2	Зорилт 12.2 2030 он гэхэд байгалийн баялгийг үр ашгтай хэрэглэж, түүний тогтвортой менежментийг бүрдүүлэх	8.4.1 Материалын өгөөж (МӨ) ба нэг хүнд ногдох МӨ, ДНБ-д ногдох материалын өгөөж 8.4.2. - Дотоодын материалын хэрэглээ, - нэг хүнд ногдох дотоодын материалын хэрэглээ, - ДНБ-д ногдох дотоодын материалын хэрэглээ	Байгалийн нөөц, баялгийг үр ашгтай ашиглахад ямар нөлөө үзүүлэх вэ?	Байгалийн нөөц, баялгийг үр ашгтай ойлголт. Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1-д "Монгол Улсад Гаазар, Түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна." гэж заасан. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/367 Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.24-д, "ашигт малтмалын баялаг" гэж геологийн зургалал, сэдэвчилсэн судалгаа, эрэл, хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн, эдийн засгийн ач холбогдол нь нарийвчлан үнэлэгдээгүй эрдсийн зургалал, сэдэвчилсэн судалгаа, эрэл ашигт малтмалын ордон нөөц" гэж хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн нь нарийвчлан тогтоогдсон, үйлдвэрлэх аргаар олборлох боломжтой, эдийн засгийн үр ашгтай, баяжуулах технологи, олборлолтын уул техникийн нөхцөл нь тодорхойлогдсон ашигт малтмалын баялгийн хэсгийг хэлнэ. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/63?lawid=63
26	12.3	Зорилт 12.3 2030 он гэхэд жижиглэн худалдааны болон хэрэглээний түвшинд нэг хүнд ногдох дэлхийн хүнсний хаягдлыг хоёр дахин багасгаж, үйлдвэрлэлийн болон нийлүүлэлтийн тогтолцоотой холбоотойгоор гарах хүнсний алдагдал, түүний дотор ургац хураалтын дараах алдагдлыг бууруулах	12.3.1 Дэлхийн хүнсний алдагдлын индекс	Үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээний түвшинд хүнсний хаягдлыг бууруулахад ямар нөлөө үзүүлэх вэ?	

27	Зорилт 12.4 2020 он гэхэд хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын баримт бичигт нийцүүлэн химийн бодис болон бүх төрлийн хог хаягдлыг амьдралынх нь мөлчегийн хугацаанд байгаль орчинд ээлтэй байдлаар зохицуулах	12.4.1 Аюултай хог хаягдал, бусад химийн бодисын тухай байгаль орчны олон улсын олон талт гэрээ, хэлэлцээрийн дагуу мэдээлэл солилцох үүргээ биелүүлж байгаа эсэх 12.4.2. Нэг хүнд ногдох аюултай хог хаягдал, устгасан хог хаягдлын эзлэх хувь, устгалын төрлөөр	Нэг хүнд ногдох аюултай хог хаягдлыг бууруулах болон устгасан хог хаягдлын эзлэх хувийн нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	Аюултай хог хаягдлын тухай ойлголт. Хог хаягдлын тухай хуульд "аюултай хог хаягдал" гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүгэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг ойлгоно. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/12652
28	Зорилт 12.5 2030 он гэхэд хог хаягдлаас сэргийлэх, түүнийг бууруулах дахин боловсруулах, дахин хэрэглэх замаар хог хаягдал бий болгож буй хэмжээг үлэмж хэмжээгээр бууруулах	12.5.1 Хог хаягдлын дахин боловсруулалтын үндэсний түвшин, хувиар болон тонноор	Дахин боловсруулсан, ашигласан хог хаягдлын эзлэх хувийг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	Дахин боловсруулсан, дахин ашигласан хог хаягдлын тухай ойлголт. Хог хаягдлын тухай хуулийн 4.1.10-д "хог хаягдал дахин ашиглах" гэж ашиглагдаж байсан зорилгоор нь хог хаягдлыг эргүүлэн хэрэглээнд оруулахыг; 4.1.12-д "хог хаягдал дахин боловсруулах" гэж хог хаягдлаас шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг ойлгоно гэжээ. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/12652
29	Зорилт 12.6 Хувийн хэвшил, ялангуяа томоохон, үндэстэн дамнасан компаниудыг тогтвортой байдалд чиглэсэн арга ажиллагааг нэвтрүүлж, энэ талаарх мэдээллийг өөрсдийн үйл ажиллагааны тайландаа тусгаж байх явдлыг дэмжих	12.6.1 Тогтвортой байдлын тайланг хэвлэдэг компаниудын тоо	Тогтвортой байдлын тайлан гаргадаг компаниудын тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	
30	Зорилт 12.7 Үндэсний бодлого, тэргүүлэх чиглэлтэй нийцүүлэн тогтвортой байдалд чиглэсэн төрийн худалдан авах ажиллагааг дэмжих	12.7.1 Төрийн худалдан авах ажиллагааны тогтвортой бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй эсэх	Тогтвортой байдалд чиглэсэн төрийн худалдан авах ажиллагааг дэмжихэд ямар нөлөө үзүүлэх вэ?	Тогтвортой хөгжилд чиглэсэн төрийн худалдан авах үйл ажиллагаа нь "ногоон худалдан авалт"-ын тухай ойлголттой ижил юм. УИХ-аар 2014 онд батлагдсан "Ногоон хөгжлийн бодлого"-ын баримт бичигт "ногоон худалдан авалт" гэж эрчим хүч, байгалийн нөөц, байгалийн хэмнэлттэй хэрэглээ, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг хэлнэ. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/annex/details/6438?lawid=10482

31	Зорилт 12.8 2030 он гэхэд хүн бүр тогтвортой хөгжил, байгаль дэлхийтэйгээ зохицон амьдрах амьдралын хэв маягийн талаар холбогдох мэдээлэл, мэдлэгтэй болсон байх	"12.8.1. (i) Дэлхийн иргэний болон хөгжлийн боловсрол (ii) тогтвортой хөгжлийн боловсрол (iii) уур амьсгалын өөрчлөлтийн боловсролыг багтаасан"-ын асуудлыг а) боловсролын бодлого; б) сургалтын хөтөлбөр; в) багш боловсрол болон (d) суралцагчийн үнэлгээнд тусгасан байдал	Тогтвортой хөгжил, байгаль дэлхийтэйгээ зохицон амьдрах талаар мэдлэг, мэдээлэлтэй хүн амын тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	
32	Зорилт 12.а Хэрэглээний болон үйлдвэрлэлийн илүү тогтвортой бүтцэд шилжих зорилгоор шинжлэх ухааны болон технологийн чадавхаа бэхжүүлэхэд хөгжиж буй орнуудыг дэмжих	12.а.1. Байгаль орчинд ээлтэй технологи, үйлдвэрлэл, тогтвортой хэрэглээнд зориулсан судалгаа, хөгжлийн тусламжийн хэмжээ	Байгаль орчинд ээлтэй технологи, үйлдвэрлэл, тогтвортой хэрэглээнд зориулсан судалгаа, хөгжлийн тусламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн тухай ойлголт. Тогтвортой үйлдвэрлэл гэдэг нь байгалийн нөөц, баялгийг зохицой, үр ашигтай ашиглах, бохирдол, хаягдал багатай үйлдвэрлэл юм. Энэ нь Ногоон үйлдвэрлэлтэй холбоотой агуулга ижил юм. УИХ-аар 2014 онд батлагдсан "Ногоон хөгжлийн бодлого"-ын баримт бичигт "ногоон үйлдвэрлэл" гэж эрчим хүч, нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд эрсдэлгүй үйлдвэрлэлийн үйл ажиллагааг ойлгоно гэжээ. Засгийн газрын 2017 оны 290 Дүгээр тогтоолоор "Байгаль орчинд ээлтэй Дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам"-ыг баталсан. Уг журын зорилго нь Байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай, зохицой ашиглах, эрчим хүчийг хэмнэх, хүлэмжийн хийн ялгарал, хог хаягдал болон дулаан алдагдлыг багасгах, агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулахад оршино. Урамшуулал нь "Ногоон гэрчилгээ", "Эко тэмдэг" олгох тухай юм. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/amnnev/details/6438?lawid=10482
33	Зорилт 12.с Хөгжиж буй орнуудын онцгой хэрэглээг шаардлага, нөхцөл байдлыг харгалзан үзэж, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг хамгаалах байдлаар өөрсдийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж болохуйд нөлөөллийг багасгаж, үндэсний нөхцөл байдалд нийцүүлэн зах зээлийн гажилтыг арилгах, түүний дотор татварын бүтцийг өөрчлөх, байгаль орчин сөрөг нөлөө учруулж буй татаасыг аажмаар багасгах замаар урлагэн хэрэглээг өгшлүүлдэг шатах түүшний үр ашиггүй татаасыг оновчтой болгох	12.с.1 ДНБ-нд ногдох хатуу түлшний татаасны хэмжээ (үйлдвэрлэл, хэрэглээ), Нийт төсвийн зарлагад хатуу түлшинд зарцуулсан зардлын эзлэх хувь ДНБ-д 0.01 хувь, Улсын төсөвт 0.03 хувь	Хатуу түлшний (нүүрс, мод) хэрэглээ, үйлдвэрлэлд төрөөс үзүүлэх татаас/ дэмжлэгийг зохицой түвшинд хүргэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	Зохицой түвшинд гэдэг нь энэ асуултын хувьд Үндэсний хэрэглээ шаардлага, нөхцөл байдлыг харгалзан үзэж, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг хамгаалах байдлаар байгаль орчин сөрөг нөлөө учруулж буй татаасыг аажмаар багасгахыг ойлгоно.

34	13.1 Зорилт 13.1 Улс орнуудад тулгарч буй цаг ууртай холбоотой аюул осол, байгалийн гамшигийг даван туулах, тэдгээрт зохицох чадварыг бэхжүүлэх	1.5.1. Гамшгийн улмаас амь насаа алдсан, бэртэж гэмтсэн хүний тоо (мянган хүн тутам) 1.5.3. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг баталж, хэрэгжүүлсэн байх 1.5.4. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн стратеги, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө баталж, хэрэгжүүлдэг орон нутгийн засаг захиргааны эзлэх хувийг нэмэгдүүлсэн байх	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой аюул, байгалийн гамшигийг даван туулах, тэдгээрт дасан зохицох чадварыг бэхжүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	Уур амьсгалын өөрчлөлт гэдэг нь уур амьсгал байгалийн жам ёсоороо хэлбэлзэх хугацааны туршид хүний шууд болон шууд бус үйл ажиллагааны улмаас дэлхийн хийн мандлын бүтцэд гарч байгаа өөрчлөлтийн дүнд бий болсон өөрчлөлтийг хэлнэ. Уур амьсгалын өөрчлөлт нь байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөө, түүний дотор хүний үйл ажиллагааны улмаас үүснэ. УИХ-ын 2011 оны 02 дугаар тогтоол. Улаанбаатар. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/annex/details/3357?lawid=6709 Дасан зохицохуй гэдэг нь уур амьсгалын өөрчлөлтийн бодит болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаварт байгаль, нийгмийн өрхө байдлыг бууруулах, эсхүл эерэг нөлөөлөл, аятай таатай нөхцөлийг аль болох бүрэн дүүрэн ашиглахад чиглэсэн хүний үйл ажиллагаа, арга хэмжээ юм. Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хөтөлбөр. УИХ-ын 2011 оны 02 дугаар тогтоол. Улаанбаатар. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/annex/details/3357?lawid=6709
35	13.3 Зорилт 13.3 Цаг уурын өөрчлөлтийг багасгах, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, цаг уурын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргэмжүүлэх талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж, хүмүүсийн болон институтийн чадварыг сайжруулах	"13.3.1 Бага, дунд, дээд боловсролын сургалтын хөтөлбөрт гамшигийг бууруулах, дасан зохицох, нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргэмжүүлэх талаар агуулга тусгасан эсэх / интеграци хийсэн бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн тоо/	Бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөрт уур амьсгалын өөрчлөлт, гамшигийг бууруулах, дасан зохицох, урьдчилан сэргийлэх талаарх агуулга тусгасан хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх бэ?	
36	14.4 Зорилт 14.4 2020 гэхэд загас агнуурыг үр дүнтэй зохицуулах, загасыг хэт ихээр агнах хууль бусаар албан ёсны мэдээнд ордоггүй, зохицуулалтгүй загас агнуур, хор хөнөөлтэй загас агнуурын арга хэлбэрийг зогсоох, хамгийн богино хугацаанд, наад, зах нь биологийн онцлог шинжийнх дагуу хамгийн өндөр хэмжээнд, тогтвортой ашиг шим өгөх түвшинд загас сүргийг сэргээх үүднээс шинжлэх ухаанд тулгуурласан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	14.4.1 Биологийн тогтвортой түвшний загасны нөөцийн эзлэх хувь	Загасны нөөцийг тогтвортой түвшинд хадгалахад ямар нөлөө үзүүлэх вэ?	

37	Зорилт 15.1 2020 гэхэд эх газрын болон цэнгэг усны экосистем, түүний үйлчилгээ, тухайлбал, ой, ус намгархаг газар, уулархаг газар, болон говь, хээрийг олон улсын гэрээний хүрээнд хүлээсэн үүргийнхээ дагуу хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах	Ойгоор бүрхэгдсэн газрын нийт газар нутагт эзлэх хувь 15.1.2. Эх газрын болон цэнгэг усны биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг хамгаалалтад авсан байдал, экосистемийн төрлөөр	Ойгоор бүрхэгдсэн, тусгай хамгаалалтад авсан газрын хэмжээг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай ойлголт. Байгалийн бус, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх эүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад зорилгоор Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг баталсан. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг 1/ дархан цаазат газар; 2/ байгалийн цогцолборт газар; 3/ байгалийн нөөц газар; 4/ дурсгалт газар гэж ангилна. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/479?lawid=479
38	Зорилт 15.2 2020 он гэхэд бүх төрлийн ойн тогтвортой менежментийг нэвтрүүлэх явдлыг хөхүүлэн дэмжих, цөлжилтийг зогсоох, муудсан ойг сэргээх, ойжуулах, моджуулах ажлыг олон улсын түвшинд [X] хувиар нэмэгдүүлэх	15.2.1 Ойн тогтвортой менежментийн чиглэлээр гарч байгаа ахиц дэвшил	Ойг нөхөн сэргээх, ашиглах, хамгаалахад ямар нөлөө үзүүлэх вэ?	
39	Зорилт 15.3 2020 гэхэд цөлжилттэй тэмцэх, цөлжилт, ган, үерийн улмаас доройтсон газар, хөрсийг нөхөн сэргээх, газрын доройлтыг зогсоох нөхцөлийг бүрдүүлэх	15.3.1. Доройтсон газар нутгийн нийт газар нутагт эзлэх хувь	Цөлжилт, газрын доройлтыг бууруулахад ямар нөлөө үзүүлэх вэ?	Цөлжилт, газрын доройлтын тухай ойлголт. НҮБ-ийн тодорхойлсноор цөлжилт нөлөөгөөр хэт хуурай, хуурай, жагсаа хуурай нутаг дэвсгэрт газрын үржил шим муудах буюу газрын биологийн болон эдийн засгийн бүтээмж багасахыг хэлнэ. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 4.1.3-д "Цөлжилт" гэж уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагаа зэрэг бусад хүчин зүйлийн нөлөөгөөр хөрс доройтох үйл явцыг, 4.1.6-д "цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээ" гэж цөлжих нөхцөл байдлыг илрүүлэх, мэдээлэх, хөрсийг сайжруулахад чиглэсэн цөлжилтөөс зайлсхийх үйл ажиллагааг, 4.1.7-д "Цөлжилтийг сааруулах арга хэмжээ" гэж цөлжилтийн эсрэг техникийн болон биологийн үйл ажиллагаа явуулж, түүнийг тархалт, идэвхжилт, үйл явцыг удаашруулах, тогтоох арга хэмжээг, 4.1.8-д "цөлжилттэй тэмцэх арга хэмжээ" гэж хөрсний доройтол, цөлжилтийн тархалт, идэвхжилтийг бууруулах, зогсоох, сөрөг нөлөөллийг арилгах үйл ажиллагааг тус тус ойлгоно гэж заасан. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/8664 Газрын доройтол гэж үйлдвэрлэл, үйлчилгээ болон газар ашиглалт, менежментийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн газар тариалан, хадлан, бэлчээрийн талбай, ой, ойн сан бүхий газрын биологийн эсвэл эдийн засгийн бүтээмж буурах, бүрмөсөн алдахыг хэлнэ. Эх сурвалж: "Байгаль орчны статистик үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлал" батлах тухай Үндэсний статистикийн хорооны даргын 2019.09.16-ны өдрийн А/135 дугаар тушаал. Улаанбаатар.
40	Зорилт 15.4 2030 он гэхэд уулархаг газрын экосистем, түүний биологийн олон янз байдлыг хадгалах замаар тогтвортой хөгжилд уулархаг газрын экосистемээс оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх чадавхыг сайжруулах	15.4.1. Өндөр уулын биологийн олон янз байдлын хувьд чухал ач холбогдолтой хамгаалагдсан газар нутгийн эзлэх хувь 15.4.2. Уулархаг газрын ургамалан нөмрөгийн индекс	Өндөр уулын бүсийн экосистем (биологийн олон янз байдал хамаарна)-ыг хамгаалахад ямар нөлөө үзүүлэх вэ?	

41	15.5	Зорилт 15.5 Биологийн олон янз байдлын амьдрах орчны доройлыг бууруулахад чиглэсэн нэн яаралтай, дорвитой арга хэмжээ авах, биологийн олон янз байдлын хомсдлыг зогсоох. 2020 он гэхэд устах аюулд орсон зүйлийг хамгаалах, устахаас сэргийлэх	15.5.1. Улаан дансны индекс	Биологийн олон янз байдлын хомсдол, амьдрах орчны доройлыг зогсооход ямар нөлөө үзүүлэх вэ?	<p>Биологийн олон янз байдал гэдэг нь Застийн газрын 2015 оны 325 дугаар тогтоолоор баталсан "Биологийн олон янз байдлын Үндэсний хөтөлбөр"-т тодорхойлснаар "дэлхий дээрх амьд бие организм олон янз байдла тухайлбал хуурай газар, далай тэнгис, усан орчны экосистем, экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох амьтан, ургамал зэрэг амьд биет болон тэдгээрийн генетикийн олон янз байдлыг багтаасан нийлмэл ойлголт юм" гэжээ. НУБ-ын Биологийн олон янз байдлын тухай конвенцийг Монгол Улсын Их Хурал 1993 онд соёрхон баталсан. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/ampex/details/6909?lawid=11359</p>
42	15.6	Зорилт 15.6 Олон улсын хэмжээнд хэлэлцэж тохирсны дагуу генетик нөөц ашигласны үр шимийг шударга, тэгш хүртээх, уг нөөцийг зохиистой ашиглах нөхцөлийг бүрдүүлэх	15.6.1. Генетик нөөцийн үр шимийг шударга, тэгш хүртээхэд чиглэсэн эрх зүй, удирдлага болон бодлогыг баталсан эсэх	<p>Биологийн олон янз байдлын тухай Конвенцийн Генетик нөөц болон тэдгээрийг ашигласнаас үүдэх үр ашгийг шударга, эрх тэгш хуваарилах тухай Нагоягийн Протоколыг 2012 онд УИХ-аар соёрхон баталсан. Уг конвенцид "Биологийн нөөц" гэдэгт генетикийн нөөц, организм эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэг, бүлгэмдэл, хүн төрөлхтөнд бодит болон боломжит ашиг тус, үнэ цэнэ бүхий экосистемийн бусад бүх бүрэлдэхүүн хэсгийг багтаана.</p> <p>"Генетикийн нөөц" гэж бодит эсхүл боломжит үнэ цэнэ бүхий генетикийн материалыг хэлнэ. "Генетикийн материал" гэж ургамал, амьтан, бичил биетний болон удамшлын функционал нэгжийг агуулсан өөр гарлын материал ойлгоно гэж заасан. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/10303</p> <p>Ерөнхийдөө Нүдэнд үл үзэгдэгч эсийн бүтэцгүй вирус, бактери, эгэл биетэн замаг, мөөгөнцөр, бүх төрлийн дээд, доод ургамал, сээр нуруугүй болон сээр нуруутан амьтад, өөрөөр хэлбэл энэ дэлхий дээр оршин тогтнож буй бүхий л амьд биес генетик материалыг өөртөө агуулж байдаг. Амьтан, ургамал, бичил биетний генетик материал, тэдгээрээс гаралтай ашигтай бодис, биохимийн ашигтай бүрэлдэхүүн хэсгүүд, ашигтай генийг генетик нөөц гэж ойлгож болно. Эх сурвалж: https://www.unmp.org/content/dam/mongolia/Publications/Environment/abs-project/what%20is%20Genetic%20resources.pdf, https://kon.mn/n/116p</p>	

43	43	<p>Зорилт 15.7 Ургамлын болон амьтны аймгийн хамгаалагдсан төрөл зүйлийг хулгайгаар агнах, хууль бусаар наймаалах явдлыг зогсоох, зэрлэг амьтан, ургамлын хууль бус бүтээгдэхүүнүүдийг эрэлт, нийлүүлэлтийг шийдэх чиглэлээр яаралтай арга хэмжээ авах</p>	<p>Ургамлын болон амьтны аймгийн хамгаалагдсан төрөл зүйлийг хууль бусаар агнах, зэрлэг ан амьтдын худалдааг багасгахад ямар нөлөө үзүүлэх вэ?</p>	<p>Ургамал, амьтны аймгийн хамгаалагдсан төрөл зүйл гэж 1973 онд анх гарын үсэг зурсан хотын нэрээр "Вашингтоны конвенци" буюу англи хэл дээрх товчлол болох "CITES" гэсэн нэрээр танил болсон "Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци"-ийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг хэлнэ. Уг конвенци нь амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах явдлыг зохицуулдаг олон улсын хэмжээний эрх зүйн акт юм. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/10701</p> <p>Уг конвенцийг хэрэгжүүлэхээр "Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль"-ийг 2002 онд УИХ-аар баталсан. Уг хуулийн зорилт нь зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенци /цаашид "Конвенци" гэж-ийг хэрэгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсад худалдаалах зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/627?law-id=527</p> <p>Мөн Амьтны тухай хуульд "нэн ховор амьтан", "ховор амьтан"-тай холбоотой харилцааг зохицуулж өгсөн байдаг. Нэн ховор амьтан гэж тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон амьтныг ойлгох бөгөөд Амьтны тухай хуулийн 7.1-д заасан амьтдыг хамруулна. Ховор амьтан гэж тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг ойлгох бөгөөд Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор Ховор амьтны жагсаалтыг баталсан. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/6670</p>
44	15.8	<p>15.8.1 Түрэмгийлэгч харь зүйлээс хамгаалах, хянах чиглэлээр эрх зүйн зохицуулалттай, хөрөнгө гаргадаг эсэх</p>	<p>Хуурай газар, усны экосистемд харь зүйл нэвтрэх боломж, сөрөг үр дагаврыг бууруулах, сэргийлэх арга хэмжээ авахад ямар нөлөө үзүүлэх вэ?</p>	<p>Харь зүйлийн тухай ойлголт. Байгалийн ургамалын тухай хуулийн 6/-д "харь ургамал" гэж улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар зөөвөрлөгдөн ирж, нутагшиж байгаа зүйл ургамлыг хэлнэ гэжээ. Уг хуулийн дагуу Харь ургамлыг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр байгальд тарималжуулахыг хориглодог. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/76?lawid=76</p> <p>Засгийн газрын 2015 оны 325 дугаар тогтоолоор баталсан "Биологийн олон янз байдлын Үндэсний хөтөлбөр"-ийн 4.10.2-д "Монгол оронд тархац байгаа харь зүйл амьтан, ургамлыг судлах, түрэмгийлэгч харь зүйлийг тархан суурьшихаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх" гэсэн зорилтыг дэвшүүлж, улмаар харь зүйлийн амьтан, ургамлын бүртгэл хийж мэдээллийн сан бүрдүүлэх арга хэмжээг дэвшүүлсэн байдаг. Ерөнхийдөө, харь зүйл гэдэгт шинэ орчинд амархан дасан зохицож улмаар давамгайлж нутгийн унаган зүйлийн шашан зайлуулж чухдаа болзошгүй шавьж, ургамал, амьтныг хэлнэ. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/annex/details/6909?lawid=11359</p>

45	Зорилт 15.9.2020 он гэхэд экосистем, биологийн олон янз байдлын үнэ цэнийг үндэсний болон орон нутгийн төлөвлөлт, хөгжлийн бодлого, ядуурлыг бууруулах стратеги, тооцоонд тусгах	15.9.1 Биологийн олон янз байдлын 2011–2020 стратеги төлөвлөгөөний Айчн-н биологийн олон янз байдлын зорилт 2-т нийцүүлэн үндэсний зорилтын хэрэгжилтийн ахиц	Экосистем, биологийн олон янз байдлын үнэ цэнийг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тооцоонд тусгахад ямар нөлөө үзүүлэх вэ?	Экосистем, биологийн олон янз байдлын үнэ цэнийг ойлголт. Экосистем өөрчлөлтийн нөлөөг зохицуулах, хүний амьдралыг тэтгэх, оюуныг сэргээх үр өгөөж бүхий үйлчилгээтэй байдаг. Энэ экосистемийн үйлчилгээ тус бүр нь өөрсдийн үнэ цэнэ, өртөгтэй байх тухай ойлголт юм. УИХ-аар 2014 онд батлагдсан "Ногоон хөгжлийн бодлого"-ын баримт бичигт "экосистемийн үйлчилгээний төлбөр" гэж экосистемийн үйлчилгээг хүртэгч болон уг үйлчилгээг тогтвортой хадгалахад хувь нэмрээ оруулагчийн хооронд бий болгох төлбөрийн зохицуулалтын механизмыг хэлнэ гэжээ. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/annex/details/6438?lawid=10482 Мөн Засгийн газрын 2015 оны 325 Дугаар тогтоолоор баталсан Биологийн олон янз байдлын Үндэсний хөтөлбөрийн 4.6.3-д "бэлчээр, усны нөөц, ойн экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, ач холбогдлыг тооцож нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг тогтвортой хадгалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх" зорилтыг мөн 4.8.2-д "биологийн олон янз байдлын үнэ цэнэ, ач холбогдол, хамгаалал, зохистой ашиглах талаарх мэдээллийг шийдвэр гаргагч болон олон нийтэд ойлгомжтой, системтэйгээр хүргэх тогтолцоог бүрдүүлэх" зорилтуудыг тус тус тодорхойлсон. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/annex/details/6909?lawid=11359
46	Зорилт 15.а Биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах, тогтвортой ашиглах үүднээс бүх төрлийн эх үүсвэрээс санхүү хөрөнгө бүрдүүлэх, түүний хэмжээг нь ихээхэн нэмэгдүүлэх	15.а.1. Биологийн олон янз байдал, экосистемийг тогтвортой ашиглах, хамгаалахад чиглэсэн албан ёсны хөгжлийн тусламж болон засгийн газрын төсвийн зарлагын хэмжээ	Биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах, тогтвортой ашиглахад зориулсан санхүүгийн эх үүсвэр, хөрөнгө бүрдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	Биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах, тогтвортой ашиглахад чиглэсэн санхүүжилт, хөрөнгө оруулалтыг "ногоон санхүүжилт"-ийг агуулгаар ойлгож болно. УИХ-аар 2014 онд батлагдсан "Ногоон хөгжлийн бодлого"-ын баримт бичигт "ногоон санхүүжилт" гэж байгалийн нөөц баялаг, экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг хадгалж, эрчим хүч, түүхий эд материал, усны хэрэглээг багасгах технологи ашиглах төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх, тэдгээрт хөрөнгө оруулахыг хэлнэ гэжээ. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/annex/details/6438?lawid=10482
47	Зорилт 15.б Тогтвортой ойн менежментийг санхүүжүүлэх зорилгоор бүх түвшинд, бүх төрлийн эх үүсвэрээс ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө бүрдүүлэх, энэ төрлийн менежмент, түүний дотор ойт хамгаалах, ойжуулах менежментийг хөгжүүлэх үүднээс хөгжиж буй орнуудад, түлхэц болохуйц урамшуулал олгох	15.б.1. Биологийн олон янз байдал, экосистемийг тогтвортой ашиглах, хамгаалахад чиглэсэн албан ёсны хөгжлийн тусламж болон засгийн газрын төсвийн зарлагын хэмжээ	Ойн нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалахад чиглэсэн албан ёсны хөгжлийн тусламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлэх вэ?	
48	Зорилт 15.с Нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг чадавхыг бэхжүүлэх замаар ургамал, амьтны хууль бусаар агнах, бэлтгэх, арилжаалхтай тэмцэхэд чиглэсэн дэлхий дахины дэмжлэгийг нэмэгдүүлэх	15.с.1 Худалдаалагдсан зүйлийн доторх хууль бусаар амьтан, ургамлыг бэлтгэсэн, ашигласан, тээвэрлэсэн зөрчилтэй эзлэх хувь, хэмжээ	Ургамал, амьтны хууль бус бэлтгэлт, ашиглалт, тээвэрлэлтийг бууруулахад ямар нөлөө үзүүлэх вэ?	Ургамал, амьтны хууль бус бэлтгэлт, ашиглалт, тээвэрлэлтийн тухай ойлголт. Зэрлэг амьтан ба ургамалын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцид бүртгэгдсэн амьтан, ургамал, Монгол Улсын хуулиар нэн ховор, ховор амьтны жагсаалтад орсон амьтан ургамалыг агнах, түүх, хуулиар агнах, барихыг түр хориглосон ан амьтны агнах үйл ажиллагаа, хууль бусаар бэлтгэсэн мод, ургамал, Улсын тусгай хамгаалалттай газар нутгаас түүсэн ургамал, барьсан, тэжээж гаршуулсан, агнасан ан амьтан, тэдгээрийн түүхий эд зүйлийн хадгалалт, худалдаа, худалдан авалт, тээвэрлэлт зэргийг хамруулна. Эх сурвалж: Эх сурвалж: "Байгаль орчны статистик үндсэн зүйлчилгээний тооцоо аргачлал" батлах тухай Үндэсний статистикийн хорооны даргын 2019.09.16-ны өрдин А/135 дугаар тушаал, Улаанбаатар.

Ашигласан эх сурвалж

HABITAT III. (огноо байхгүй). The New Urban Agenda. The United Nations Conference on Housing and Sustainable Urban Development. <http://habitat3.org/the-new-urbanagenda/>

Барилга, хот байгуулалтын яам. (2017). Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төсөл.

Дэлхийн өв. (2019). ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс. <http://www.unesco.mn/p/144>

М.Алтанбагана, Б.Хэрлэнбаяр, Б.Сувданцэцэг, Т.Чулуун, Х.Номинболор. (2015). Эмзэг байдлын үнэлгээнд тулгуурлан ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх нь. Монгол орны бэлчээрийн сэргэн хөгжих чадавхийг бэхжүүлэх нь сэдэвт салбар хөрвөсөн олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, хуудас 195-200.

М.Алтанбагана, Б.Хэрлэнбаяр, Б.Сувданцэцэг, Х.Номинболор. (2015). "Ногоон хөгжлийн тэргүүлэх 5 аймгийн сумдын байгаль орчин, нийгмийн эмзэг байдлын судалгаа хийж, бодлогын санал зөвлөмж боловсруулах" бодлогын судалгааны тайлан. Үндэсний хөгжлийн хүрээлэн. Улаанбаатар хот.

Монгол Улсын Засгийн газар. (2013 оны 11 дүгээр сарын 30). Монгол Улсын усны нэгдсэн менежментийн арга хэмжээний төлөвлөгөө. Засгийн газрын 389 дүгээр тогтоолын хавсралт.

Монгол Улсын Засгийн газар. (2015 оны 8 дугаар сарын 4). Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 325 дугаар тогтоолын хавсралт.

Монгол Улсын Засгийн газар. (2017 оны 12 дугаар сарын 27). Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги. Засгийн газрын 355 дугаар тогтоолын хавсралт.

Монгол Улсын Засгийн газар, United Nations Development Programme. (2012). Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн нэр томъёоны тайлбар толь /2 дахь хэвлэл/. Улаанбаатар хот.

Монгол Улсын Их Хурал. (1992 оны 1 дүгээр сарын 13). Монгол Улсын Үндсэн хууль.

Монгол Улсын Их Хурал. (1994 оны 11 дүгээр сарын 15). Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль.

Монгол Улсын Их Хурал. (1995 оны 4 дүгээр сарын 11). Байгалийн ургамлын тухай хууль.

Монгол Улсын Их Хурал. (2002 оны 11 дүгээр сарын 7). Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль.

Монгол Улсын Их Хурал. (2006 оны 5 дугаар сарын 25). Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль.

Монгол Улсын Их Хурал. (2007 оны 1 дүгээр сарын 11). Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль.

Монгол Улсын Их Хурал. (2010 оны 5 дугаар сарын 20). Монгол мал үндэсний хөтөлбөр.

Монгол Улсын Их Хурлын 23 дугаар тогтоолын хавсралт.

Монгол Улсын Их Хурал. (2011 оны 1 сарын 6). Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр . Монгол Улсын Их Хурлын 2011 оны 2 дугаар тогтоолын хавсралт.

Монгол Улсын Их Хурал. (2011 оны 10 дугаар сарын 6). Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/.

Монгол Улсын Их Хурал. (2012 оны 5 дугаар сарын 17). Амьтны тухай хууль /Шинэчилсэн найруулга/.

Монгол Улсын Их Хурал. (2012 оны 12 сарын 20). Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Генетик нөөц болон тэдгээрийг ашигласнаас үүдэх үр ашгийг шударга, эрх тэгш хуваарилах тухай Нагоягийн протоколыг соёрхон батлах тухай хууль.

Монгол Улсын Их Хурал. (2012 оны 5 сарын 17). Усны тухай хууль /Шинэчилсэн найруулга/.

Монгол Улсын Их Хурал. (2012 оны 5 сарын 17). Усны тухай хууль /Шинэчилсэн найруулга/.

Монгол Улсын Их Хурал. (2012 оны 5 дугаар сарын 17). Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль .

Монгол Улсын Их Хурал. (2014 оны 6 дугаар сарын 13). Ногоон хөгжлийн бодлого. Монгол Улсын Их Хурлын 43 дугаар тогтоолын хавсралт.

Монгол Улсын Их Хурал. (2015 оны 6 дугаар сарын 19). Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого. Монгол Улсын Их Хурлын 63 дугаар тогтоолын хавсралт.

Монгол Улсын Их Хурал. (2015 оны 11 дүгээр сарын 26). Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль.

Монгол Улсын Их Хурал. (2017 оны 12 дугаар сарын 14). Малын генетик нөөцийн тухай хууль.

Монгол Улсын Их Хурал. (2017 оны 5 дугаар сарын 12). Хог хаягдлын тухай хууль / Шинэчилсэн найруулга/.

НҮБ. (1973 оны 3 дугаар сарын 3). Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц. Вашингтон хот.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль Орчны Хөтөлбөр /UNEP/. (1992 оны 6 дугаар сарын 5). Биологийн олон янз байдлын тухай конвенци. Монгол Улсын олон улсын гэрээ.

Төв Азийн Усны Нөөцийн Нэгдсэн Менежмент: Загвар бүс нутаг Монгол төсөл. (2019). УННМ гэж юу вэ? УННМ МоМо төсөл. http://www.iwrm-momo.de/iwrm_m.htm

ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс. (2019). www.unesco.mn. <http://www.unesco.mn/p/47>